



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

Засгийн газрын 4 дүгээр байр, Бага тойруу-3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: (976-51) 26 44 44, Факс: (976-51) 26 41 24,
Цахим шуудан: info@frc.mn, Цахим хуудас: www.frc.mn

2026.04.08 № 1 / 1209
танай _____-ны № _____-т

Тайлан хүргүүлэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 4.3-т заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны Үйл ажиллагааны тайланг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргад Хорооны 2026 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 1/1148 тоот албан бичгээр хүргүүлсэн.

Тус Хорооны үйл ажиллагааны болон системчилсэн үнэлгээний тайлан, санхүүгийн салбарын тоймыг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт: Үйл ажиллагааны тайлан 40 ширхэг, санхүүгийн салбарын тойм 40 ширхэг, системчилсэн үнэлгээний тайлан 48 хуудастай.

Хүндэтгэсэн.

ДАРГА

Т.ЖАМБААЖАМЦ



1518000144



**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ 2025 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СИСТЕМЧИЛСЭН
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**



Улаанбаатар хот
2026 он

АГУУЛГА

НЭГ. СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨРӨЛ	4
БОЛОН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫГ ТОГТООХ ҮНЭЛГЭЭ.....	4
1.1 БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРЭГ, БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	4
1.2 БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА	5
1.3 ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА	24
1.4 ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА	25
ХОЁР. ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛД ХИЙХ	33
ДҮН ШИНЖИЛГЭЭ БА ХАРЬЦУУЛАЛТ	33
ГУРАВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ.....	45

ТОВЧИЛСОН ҮГСНИЙН ЖАГСААЛТ

АНДМУТБ	Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэг
АХБ	Азийн Хөгжлийн Банк
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
БОНЗ	Байгаль орчин, нийгэм, засаглал
ВХҮҮ	Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДХЧ	Даатгалын хяналтын чиглэл
ЖДХ	Жигнэсэн дундаж хүү
ЗБДС	Зээлийн батлан даалтын сан
ЗЖДХ	Зээлийн жигнэсэн дундаж хүү
МУТА	Мөнгө угаахтай тэмцэх алба
МУТСТ	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх
МУХАҮТ	Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим
МЗҮЭ	Мөнгөн зээлийн үйлчилгээ эрхлэгч
МҮЭ	Мэдээлэх үүрэгтэй этгээд
МХБ	Монголын хөрөнгийн бирж
НХЭГ	Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
СМА	Санхүүгийн мэдээллийн алба
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТББ	Төрийн бус байгууллага
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ОУСК	Олон Улсын Санхүүгийн Корпорац
УБАШ	Улсын байцаагчийн албан шаардлага
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
УИХ	Улсын Их Хурал
УУБББАЗ	Уул уурхайн бүтээгдэхүүний бирж болон биржийн арилжааны зуучлагч
ҮМҮЧЭТХЭАЭ	Үнэт металл, үнэт чулууны эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч
ҮХХЗ	Үл хөдлөх хөрөнгө зуучлал
ҮХЭХБХСЗ	Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлал
ҮХЭХЗ	Үл хөдлөх эд хөрөнгө зуучлал
ҮЦК	Үнэт цаасны компани
ФАТФ	Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага
ХААБ	Хөдөө аж ахуйн бирж
ХЗЗ	Хөдөлмөрийн зах зээл
ХЗХ	Хадгаламж зээлийн хоршоо
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХЗХХЧ	Хадгаламж зээлийн хоршооны хяналтын чиглэл
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭЗБХ	Эдийн засгийн байнгын хороо
ADB	Asian Development Bank /Азийн хөгжлийн банк/
ACC	Association of Asian Confederation of Credit Unions
AFI	Alliance for Financial Inclusion
DvP	Delivery versus payment /Төлбөрийн эсрэг нийлүүлэлт/
FSA	Financial Services Agency /Санхүүгийн үйлчилгээний агентлаг/
IPO	Initial public offering /Олон нийтэд хувьцаагаа санал болгох/
REIT	Real Estate Investment Trust /Үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалтын сан/
ICURN	International Credit Union Regulators' Network
IGF	International Guarantee Fund буюу /Олон улсын батлан даалтын сан/
VACG	Virtual Asset Contact Group
ISO	International Organization for Standardization /Үр ашиг, нийцлийн шаардлагыг тодорхойлсон стандарт/

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2026.03.18

Улаанбаатар хот

Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2013 оны “Системчилсэн үнэлгээ хийх тухай” 05 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “СЗХ” гэх/-ны 2025 оны үйл ажиллагаанд Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 2011 оны 55 дугаар тушаалаар баталсан “Байгууллагын үйл ажиллагаанд системчилсэн үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу дүн шинжилгээ хийж, үнэлгээ өгсөн болно.

НЭГ. СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨРӨЛ БОЛОН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫГ ТОГТООХ ҮНЭЛГЭЭ


Үнэлгээ нь байгууллагын үйл ажиллагааны хэрэгжилтийн үр дүн, тавьсан зорилгодоо хүрсэн эсэхийг тодорхойлоход чиглэх бөгөөд “Дотоодын буюу өөрийн байгууллагын үнэлгээ”-ний хэлбэрийг сонгож, дараах төрлөөр үнэлгээ хийлээ. Үүнд:

1. Байгууллагын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт;
2. Байгууллагын үндсэн үйл ажиллагаа;
3. Гадаад харилцаа, хамтын ажиллагаа;
4. Дотоод үйл ажиллагаа.

1.1 БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРЭГ, БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Тус хороо нь Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд зааснаар санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Зураг 1. Санхүүгийн зохицуулах хорооны бүтэц, зохион байгуулалт.




СЗХ-ны Ажлын алба нь 2025 онд 9 газар, 5 хэлтэс, 6 албанд нийт 190 албан хаагчтайгаар 11 салбарын 5,930 /даатгалын төлөөлөгч-1,143/ зохицуулалттай этгээдэд хяналт тавьж, бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлжээ. Мөн орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй зохицуулалтын байгууллагуудын нэгдсэн бүртгэл хөтөлж, шаардлагатай мэдээллийг тогтоосон хугацаанд СЗХ-нд ирүүлэх, хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах, зохицуулалтын байгууллагуудад хяналт тавих үүрэг бүхий орон нутгийн 63 төлөөлөгч Монгол Улсын 21 аймаг, нийслэлийн 9 дүүрэгт ажиллаж байна.

1.2 БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд СЗХ нь санхүүгийн үйлчилгээтэй холбоотой хууль тогтоомж, дүрэм журам, заавар батлах, шаардлагатай шалгуур үзүүлэлт, бусад хэм хэмжээг тогтоох чиг үүргийг хэрэгжүүлж Монгол Улсын Их Хурлаас баталсан 29 /Үнэт цаас-6, Даатгал-5, ББСБ-3, ХЗХ-1, ВХҮҮ-1, МЗҮЭ-1, УУБББА3-1, Нийт салбар-11/ хууль тогтоомжид нийцүүлсэн 51 хэм хэмжээний актыг батлан мөрдүүлж, тэдгээрийн биелэлтэд хяналт тавьж ажилласан.

График 1



Зохицуулалттай салбарын мэргэжлийн үйл ажиллагааны эрх зүйн орчинг зах зээлийн хөгжилтэй нийцүүлэх, боловсронгуй болгох, давхардал, хийдэл арилгах ажлын хүрээнд шинээр 4, шинэчлэн баталсан 14, нэмэлт, өөрчлөлт оруулсан 14 акт байгаа бол 15 актыг хүчингүй болгосон байна.

Дээд газрын 10 тогтоолын 184 арга хэмжээний хэрэгжилтэд үнэлгээ хийж, холбогдох байгууллагуудад хуулийн хугацаанд хүргүүлсэн бөгөөд СЗХ-ны үйл ажиллагаанд шууд хамааралтай тогтоол, шийдвэрүүдийн биелэлтэд хяналт тавин ажилласан байна.

Санхүүгийн зохицуулах хорооны 2022-2025 оны стратеги төлөвлөгөөний 4 зорилго, 9 зорилт, 75 арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан бөгөөд 2025 онд төлөвлөгөөний хэрэгжилт 92.2 хувтай үнэлэгдсэн. Үнэлгээний үр дүнг багцлан үзвэл 81 ба түүнээс дээш хувийн биелэлттэй 61 арга хэмжээ, 51–80 хувийн биелэлттэй 10 арга хэмжээ, 50 ба түүнээс доош хувийн биелэлттэй 4 арга хэмжээ байна.

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт “Хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна” гэж заасан бөгөөд Хороо нь сард 2-оос доошгүй удаа тогтмол хуралдаж байна.

Тайлант хугацаанд СЗХ-оос баталсан тогтоол, тушаал, шийдвэрүүд:

*Хүснэгт 1. СЗХ-ны хуралдаан, СЗХ-ны даргын болон
Ажлын албаны даргын шийдвэрүүдийн дэлгэрэнгүй мэдээлэл:*

№	Ангилал		Тоо	Шийдвэрлэлт
1	Хорооны хуралдаан	Хорооны тогтоол	509	Тайлант хугацаанд СЗХ-ны ээлжит хуралдаан 21 удаа хуралдаж, 420 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн байна. * Үндсэн үйл ажиллагаа -137, хүний нөөц-256
2	Хорооны дарга	Тушаал	509	
3	Ажлын албаны дарга	Тушаал	393*	

Хуралдаанаар шийдвэрлүүлсэн асуудлыг газар, нэгжээр нь авч үзвэл:

Үнэт цаасны газар – 142,

Даатгалын газар – 42,

Банк бус санхүүгийн байгууллагын газар –55,

Мөнгөн зээлийн зохицуулалтын алба – 8,

Хадгаламж зээлийн хориооны газар – 10,

Хяналт шалгалт, зохицуулалтын газар – 88,

Үл хөдлөх хөрөнгө зуучлал, үнэт эдлэлийн зохицуулалтын газар – 58,

Вертуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн хэлтэс – 3,

Захиргаа удирдлагын газар – 5,

Компанийн засаглал, комплайнсын хэлтэс – 3,

Хууль эрх зүйн хэлтэс – 4,

Сэндбоксын алба – 1,

Мэдээллийн технологийн хэлтэс – 1 асуудлыг тус тус хэлэлцүүлж шийдвэрлүүлсэн байна.

1.2.1 САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ БОЛОН САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ, ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ:

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл 2025 онд ээлжит хуралдаан 4 удаа, ээлжит бус хуралдааныг 3 удаа зохион байгуулж, нийт 20 асуудал хэлэлцсэн байна. Үүнд:

- 1) Макро эдийн засгийн нөхцөл байдал, төсвийн гүйцэтгэл;
- 2) Эдийн засгийн өнөөгийн төлөв;
- 3) Банкны харилцах дансанд хүү тооцох зохицуулалт;
- 4) Уул уурхайн биржийн журмын өөрчлөлт, шинэчлэлт;

- 5) Монгол Улсын гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлэх чиглэлд авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай;
- 6) Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлэхээр төлөвлөж буй “Алт-3 аян”-ы хүрээнд олон улсын зах зээлээс урьдчилгаа санхүүжилт татах тухай;
- 7) Гадаад валютын улсын нөөцийн өөрчлөлт, алтны санхүүжилтийн явцын тухай;
- 8) Банкны салбарын гадаад валютын орох урсгалыг дэмжих саналын тухай;
- 9) Засгийн газрын дотоод үнэт цаасны нээлттэй арилжааны тухай;
- 10) Монгол Улсын төлбөрийн тэнцлийн тойм;
- 11) Гадаад валютын албан нөөцийн тухай;
- 12) Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжааны тайлан;
- 13) Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичиг;
- 14) Төрөөс мөнгөний бодлогын талаар 2026 онд баримтлах үндсэн чиглэлийн төслийн танилцуулга;
- 15) Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжааны танилцуулга;
- 16) Үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалтын итгэлцлийг Монгол Улсад нэвтрүүлэх боломжийн талаарх танилцуулга;
- 17) Макро эдийн засгийн төлөв;
- 18) Олон улсын төлбөр тооцооны тухай;
- 19) Санхүүгийн зохицуулах хорооноос банк бус санхүүгийн салбарт авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай;
- 20) Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн 2026 оны ээлжит хурлын тов тогтоох тухай асуудлууд багтжээ.

Санхүүгийн зохицуулах хорооноос дээрх асуудлуудад хамаарах материалтай танилцан холбогдох хариу, тайлбарыг хүргүүлж ажилласан бөгөөд эдийн засгийн дотоод эрэлтийг төсөв, мөнгө, санхүүгийн бодлогын зохицуулалтаар зохистой удирдан, гадаад, дотоод тэнцвэр алдагдахаас хамгаалах шаардлагатай асуудлуудыг зөвлөлийн хуралд танилцуулж ажилласан. Мөн экспортын орлогыг нэмэгдүүлж, экспортын саад тотгорыг арилгах, хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс сэргийлэх арга хэмжээний саналыг Засгийн газарт танилцуулах, Уул уурхайн биржийн арилжаатай холбоотой түр журмын төслийг Санхүүгийн зохицуулах хорооны хуралдаанаар яаралтай хэлэлцүүлэх, банкны харилцах дансанд тогтоосон хүүний дээд хязгаар 3 хувийг хэвээр хадгалах нь зүйтэй гэсэн шийдвэрийг гаргаж зөвлөмж хүргэсэн.

Монгол Улсын Засгийн газрын үнэт цаасны хөрвөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор Хадгаламжийн даатгалын корпорацын эзэмшиж буй Засгийн газрын гадаад үнэт цаасыг олон улсад арилжаалах зохицуулалтыг хийв. Үүнтэй уялдуулан Төсвийн тухай хуулийн хүрээнд

Засгийн газрын дотоод үнэт цаас гаргах, Хадгаламжийн даатгалын корпорацын эзэмшиж буй Монгол Улсын Засгийн газрын гадаад бондыг үнийн хэлбэлзэл үүсгэхгүйгээр арилжаалж, чөлөөлөгдөх гадаад валютын нөөцийг Монгол Улсын дотоод зах зээлд оруулж ирэх зөвлөмжийг Хадгаламжийн даатгалын корпорацад хүргүүлж шийдвэрлэсэн.

Санхүүгийн зохицуулах хорооны хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх, санхүүгийн зах зээлийн бодлогыг тодорхойлох, зохицуулах, хянахтай холбоотой үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх чиг үүрэгтэй “Бодлогын зөвлөл” нь 2025 онд 7 удаа хуралдаж дараах санал, зөвлөмжийг гаргасан. Үүнд:

✚ “Үнэт цаасны бодлогын зөвлөл”-ийн ээлжит хуралдаанаар “Тадаадын иргэн аж ахуйн нэгжүүдийн Монгол Улсын хөрөнгийн зах зээлд оролцох оролцоог нэмэгдүүлэх, үнэт цаасны данс нээх үйл ажиллагааг хялбаршуулах чиглэлээр шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий ажлын хэсгийн тайлан”, “Үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйлчилгээний журам”-ын танилцуулсан байна. Мөн “Хөрөнгийн зах зээлийн татварын орчныг сайжруулах” чиглэлээр хийгдсэн ажлууд болон цаашид хийхээр төлөвлөж буй асуудлууд”-ыг хэлэлцүүлж, зөвлөлийн хурлаас хөрөнгийн зах зээлийн хөгжүүлэх Санал дугаар №1 зөвлөмжийг гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлэн хэрэгжилтэд нь хяналт тавьж ажилласан.

✚ “Даатгалын бодлогын зөвлөл”-ийн ээлжит хуралдаанаар даатгалын баталгаа гаргах үйл ажиллагаатай холбоотой “Даатгалын багц дүрэмд өөрчлөлт оруулах тухай” тогтоолын төсөл, “Даатгалын салбарын өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлууд, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ”, “Даатгалын бодлогын зөвлөлийн 2024 оны №1 тоот зөвлөмжийн хэрэгжилт”, “Хорооноос авч хэрэгжүүлж буй зарим арга хэмжээ”-ний талаар тус тус танилцуулсан.

Даатгалын бодлогын зөвлөлийн хурлаас Зөвлөмж №1-ийг гаргасан бөгөөд зөвлөмжид “Даатгалын компаниудын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг нэмэгдүүлэх, даатгагчийн баталгаа гаргах үйл ажиллагааны зохицуулалтыг сайжруулах, даатгалын компаниуд өөрсдийн эрсдэлээ удирдах, олон нийтийг ил тод мэдээллээр хангаж ажиллах” арга хэмжээнүүдийг тусгаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.

✚ “Бичил санхүүгийн бодлогын зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2025 оны 449 дүгээр тушаалаар шинэчлэн байгуулсан. Зөвлөлийн хуралдаанд ББСБ-ын салбарт 2025 онд авч хэрэгжүүлсэн бодлого, арга хэмжээг танилцуулсан.

✚ “Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын зөвлөл”-ийн ээлжит хуралдаанаар “Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс олох зээлийн хүү, авч хэрэгжүүлж буй арга хэмжээ”-ний талаар танилцуулж, тус зөвлөлөөс “Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс олгох зээлийн хүүгийн дээд хэмжээг сарын 4.5 хувь хэвээр хадгалах шийдвэр”-ийг

гаргаж, уг шийдвэрийг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж зохицуулалтын салбаруудад хүргэж ажилласан.

Санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангаж, бодлого зохицуулалтын арга хэмжээг хэрэгжүүлж, зохицуулалттай салбаруудын мэргэжлийн үйл ажиллагааны зохицуулалтын орчныг зах зээлийн хөгжилтэй нийцүүлэн сайжруулах, шинээр батлагдсан эрх зүйн орчинтой нийцүүлэн холбогдох дүрэм, журам, заавар, аргачлалыг батлах чиглэлээр дараах ажлуудыг гүйцэтгэсэн байна.

1.ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Санхүүгийн зохицуулах хорооноос хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийг хөгжүүлж, үнэт цаасны арилжаа, төлбөр тооцоог олон улсын жишигт нийцүүлэх, хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг татах цогц арга хэмжээнүүдийг үе шаттай хэрэгжүүлж, үнэт цаас гаргах ажиллагааг хялбар шуурхай болгох суурь нөхцөлийг бүрдүүлж ажилласан.

Хөрөнгийн зах зээлд санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, зах зээлд оролцох оролцоог нэмэгдүүлэх, биржийн болон биржийн бус зах зээлд үнэт цаас гарган санхүүжилт татан төвлөрүүлэлтийг нэмэгдүүлэх, бонд гаргахтай холбоотой ажиллагаанд тавигдах шалгуурыг багасгаж хялбар, шуурхай бүртгэх зорилгоор 2025 онд шинээр боловсруулсан 4, шинэчилсэн 6, нэмэлт өөрчлөлт оруулсан 4 актыг боловсруулж баталжээ.Үүнд:

СЗХ нь 2025 онд “Хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагааны журам”, “Үнэт цаасны зах зээлд арилжихаар гаргах хадгаламжийн сертификатыг бүртгэх, арилжих, тайлагнах журам”, “Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны журам” болон “Тэрээний үндсэн дээр үүсгэн байгуулах хувийн хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны журам”, Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай үйл ажиллагааны багц дүрэм”, “Уул уурхайн бүтээгдэхүүний бирж болон биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагааны журам”, “Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаа, төлбөр, тооцоо хийх ерөнхий журам” аргачлалыг баталсан.

Олон Улсын Санхүүгийн Корпорац (ОУСК)-тай байгуулсан харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд “Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулж баталснаар үнэт цаас гаргагчаас дотоодын хөрөнгийн зах зээлд “нийгмийн бонд” болон “тогтвортой байдлын бонд” гаргах боломжийг бүрдүүлсэн.

Олон улсын хөрөнгийн зах зээлд үнэт цаас зээлдүүлэх үйл ажиллагаа нь зах зээлийн хөрвөх чадварыг идэвхжүүлэх гол хэрэгсэл болж хөгжсөн байдаг. Монгол Улсын хөрөнгийн зах зээл дэх зохицуулалтын орчинг “Үнэт цаас зээлдүүлэх үйл ажиллагаа” шинэ бүтээгдэхүүн үйлчилгээгээр нэмэгдүүлснээр хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дараагийн шат руу ахиулах алхам болсон.

Санхүүгийн эх үүсвэр татах ажиллагааг хөнгөвчлөх, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын идэвх, оролцоог нэмэгдүүлэх төр, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийг бонд гаргах замаар санхүүжилт татах сонирхлыг дэмжих зорилгоор УИХ-ын даргын санаачилгаар 2025 оны 04 дүгээр сард “Бонд форум” арга хэмжээг амжилттай зохион байгуулж, СЗХ, МҮХАҮТ, Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо, “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн удирдлагууд 4 талт “Хамтын ажиллагааны санамж бичиг”-г байгуулсан. Санамж бичигт ТОП-100 аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн эх үүсвэр татах ажиллагааг хөнгөвчлөх, бонд гаргахад тавигдах нөхцөл, шаардлагыг хялбаршуулах, зах зээл дэх засаглал, манлайллыг дэмжих, хөрөнгийн зах зээлд тэдгээрийн оролцоог өсгөх, цаашлаад банкнаас бусад санхүүгийн зах зээлийг хөгжүүлэхэд дотоодын аж ахуйн нэгжүүдийг хөрөнгийн зах зээлд татан оролцуулах зэрэг арга хэмжээг тусгасан.

Санхүүгийн зохицуулах хорооны төлөөлөл “Монголын хөрөнгө оруулалтын форум “Нью-Йорк 2025”, Япон Улсад зохион байгуулагдсан “Mongolian Day” арга хэмжээнд оролцож Монголын хөрөнгийн зах зээлийн өнөөгийн нөхцөл байдал, авч хэрэгжүүлсэн онцлох ажлуудын талаар танилцуулж, санал солилцож ажилласан.

Үнэт цаас гаргагч болон зохицуулалттай этгээдээс 2025 онд бүртгэл, зөвшөөрлийн чиглэлээр нийт 320 удаагийн хүсэлт ирүүлснийг холбогдох хууль, журмын дагуу хянаж, үнэт цаас бүртгэх, бүртгэлд өөрчлөлт оруулах, тусгай болон энгийн зөвшөөрөл олгохтой холбоотой 271 асуудлыг хорооны хуралдаан, хорооны даргын тушаал, цахим мэдэгдэл, адбан бичгүүдээр тус тус шийдвэрлэсэн бол холбогдох хууль, журмын дагуу 49 хүсэлт хянагдаж байна.

Тайлант хугацаанд дотоодын үнэт цаасны арилжаа, төлбөр тооцооны систем зарчмын дагуу хэвийн явагдаж, санхүүгийн тогтвортой байдалд сөрөг нөлөө үзүүлэхүйц аливаа эрсдэл гараагүй байна.

2. ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

Даатгалын салбарын хамрах хүрээ, хүртээмжийг нэмэгдүүлэх, эрсдэлийн удирдлага, санхүүгийн чадамжийг дээшлүүлэх, зөв өрсөлдөөнийг бий болгох, салбарын тогтвортой байдлыг хангахад чиглэсэн бодлого, зохицуулалтын орчныг олон улсын чиг хандлагад нийцүүлэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:

Даатгалын салбарын эрх зүйн орчныг олон улсын жишигт нийцүүлэн сайжруулах, салбарын хөгжлийг дэмжих зорилгоор “Даатгалын салбарын багц хууль”, “Даатгалын зуучлалын тухай хууль”, “Жолоочийн даатгалын тухай хууль”-иудын шинэчилсэн найруулгын төслийг эцэслэн боловсруулсан байна.

СЗХ-ны 2025 оны 66 дугаар тогтоолоор “Даатгалын багц дүрэм”-ийг шинэчлэн баталж, холбогдох журмуудад нэмэлт өөрчлөлтийг оруулж ажилласан.

Ипотекийн даатгалын хамгаалалт дутмаг байсан асуудлыг шийдвэрлэх зорилгоор “Даатгалын багц дүрэм”-д нэмэлт, өөрчлөлт оруулж, зээлдэгчийн амь нас, эрүүл мэндийн даатгалыг урт хугацааны даатгалд төвлөрүүлэх зохицуулалтыг хийсэн.

Даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах чиг үүргийн хүрээнд Даатгалын багц дүрэм”-ийн хавсралтаар баталсан журмуудад нэмэлт, өөрчлөлт оруулан, уг төсөлд олон нийтээс санал авахаар Санхүүгийн зохицуулах хорооны цахим хуудаст байршуулж ажилласан.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын А/48 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт даатгалын газрын төлөөлөл оролцож “Хувийн нэмэлт тэтгэврийн үйл ажиллагаанд урт хугацааны даатгагч оролцох боломж, түүний зохицуулалтыг нарийвчлан сайжруулах” хүрээнд холбогдох саналуудыг өгч хамтран ажилласан.

Даатгалын бүртгэл, зөвшөөрлийн чиглэлээр нийт 1,194 хүсэлт ирүүлснээс 502 хүсэлтийг шийдвэрлэж, 1 компанийн 520 төлөөлөгчийг түдгэлзүүлэх хүсэлтийг холбогдох газарт шилжүүлж, 132 хүсэлтийг буцааж, 40 хүсэлт хянагдаж байна.

Даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах, даатгалын төлөөлөгчид мэргэшиж, төрөлжих, даатгуулагч даатгалын талаарх мэдээлэл, үйлчилгээг хүртээмжтэй авах, давхар даатгалын оролцоотойгоор бүх төрлийн баталгаа гаргах боломж бүрдэж, даатгагч өөрийн эрсдэл болон төлбөрийн чадвараа үнэлэх зохицуулалтыг боловсронгуй болгож, бодлого зохицуулалтын арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлж ажилласан.

3. БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН САЛБАР

Банк бус санхүүгийн байгууллагын салбарын тогтвортой байдлыг хангах, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах, салбарын оролцогчдыг чадавхжуулах, салбарт үүсэж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд:

СЗХ нь олон улсын санхүүгийн зах зээлд өрсөлдөхүйц, чанартай, хүртээмжтэй, цахим технологид суурилсан санхүүгийн систем, санхүүгийн хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалсан, санхүүгийн үйлчилгээг эрхлэх хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэхэд чиглэсэн Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан.

Санхүүгийн зохицуулах хорооноос журмын давхардлыг бууруулах, салбарын зохицуулалтыг сайжруулах зорилгоор Хорооны 2025 оны 68 дугаар тогтоолоор “Банк бус санхүүгийн үйл ажиллагаа болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”, “Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, хорогдуулах, шинээр хувьцаа гаргах, худалдах, шилжүүлэхэд мөрдөх журам”-ыг тус тус баталсан.

СЗХ-ны 2025 оны 77 дугаар тогтоолоор “Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулснаар хэрэглээний зээлийн бүтээгдэхүүнд

тооцох өр, орлогын харьцааг 60 хувиас хэтрэхгүй байхаар, суудлын автомашин барьцаалсан болон худалдан авах хэрэглээний зээлийн зээл, үнэлгээний харьцаа 60 хувиас хэтрэхгүй байхаар тус тус тогтоосон.

Мөн Хорооны 2025 оны 186 дугаар тогтоолоор “Банк бус санхүүгийн байгууллагаас олгох хэрэглээний зээлд өр, орлогын харьцааг тооцох аргачлал”-ыг шинэчлэн баталснаар бусдаас татан төвлөрүүлэх эх үүсвэрт хязгаарлалт тогтоов.

СЗХ-ны 2025 оны 78 дугаар тогтоолоор ББСБ-ын итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлэх эх үүсвэр нь өөрийн хөрөнгийн 80 хувь байсныг 60 хувь, өрийн бичиг өөрийн хөрөнгийн 50 хувь байсныг 30 хувь болгож, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас өөрийн хөрөнгийн 60 хувьд нь дотоодын арилжааны банк болон мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч этгээдээс эх үүсвэр татан төвлөрүүлэхгүй байх хязгаарлалтыг тогтоосноор иргэдийн өрийн дарамтыг бууруулах, хариуцлагатай зээл олголтыг төлөвшүүлэх, бизнесийн санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлогыг хэрэгжүүлж ажилласан.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасны дагуу нэр бүхий 100 ББСБ, 19,487 удаагийн тохиолдлоор 2,057.6 тэрбум төгрөгийг, мөн хуулийн 7.2-т заасны дагуу нэр бүхий 12 ББСБ, 5,554 удаагийн тохиолдлоор 38,2 тэрбум төгрөгийг Монголбанкны СМА-нд мэдээлэн хамтран ажилласан.

Зохицуулалттай этгээдийн Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 “Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээд нь жилийн санхүүгийн тайланг аудитаар баталгаажуулах, нийтэд мэдээлэх” хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.

Зээлийн мэдээллийн сангийн хуульд заасны дагуу зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй ББСБ-ууд Монголбанкны зээлийн мэдээллийн сан, “Бүрэн скор ЗМС”, болон “Титан Си Ар ЗМС”-ийн аль нэгэнтэй нь гэрээ байгуулан шаардлагатай мэдээлэл солилцон хамтран ажиллаж, шинээр болон нэмж банк бус санхүүгийн зээл олгох үйл ажиллагаа эрхлэх зохицуулалттай этгээдийг мэдээллээр ханган ажиллаж байна.

Банк бус санхүүгийн байгууллагын бүртгэл зөвшөөрлийн чиглэлээр нийт 764 хүсэлт ирүүлснээс Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай болон энгийн зөвшөөрөл олгох 55, салбар нэгж байгуулах, оноосон нэр, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах, түдгэлзүүлэх тухай 157 зөвшөөрлийг тус тус шийдвэрлэсэн. Мөн гүйцэтгэх удирдлага, хаяг байршил, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг бүртгэх, өөрчлөх 379, финтек бүтээгдэхүүнийг бүртгэх 19, хоёрдогч өглөгөөр эх үүсвэр татан төвлөрүүлсэн 17, баримт бичгийн бүрдэл хангуулахаар нэмэлт шаардаж албан бичиг хүргүүлсэн 63, хууль тогтоомжид заасан үндэслэлээр 26 хүсэлтийг шийдвэрлүүлэхээс

татгалзсан, бусад 48 албан бичгийг удирдлагад танилцуулж, нийт 552 албан бичгийг зохицуулалтын байгууллагад хүргүүлж ажилласан.

4. МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИЦУУЛАЛТ

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр СЗХ нь Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуульд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх болсноор Санхүүгийн зохицуулах хорооны 86 дугаар тогтоолоор Мөнгөн зээлийн зохицуулалтын албыг байгуулсан.

Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль батлагдаж, 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэнтэй холбогдуулан СЗХ нь дүрэм, журам, заавар баталж, хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна. Үүнд:

“Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн бүртгэл, үйл ажиллагааны журам”-ын төслийг шинэчлэн боловсруулж, баталсан;

Үндэсний хэмжээний мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээний ажлын хүрээнд Мөнгөн зээлийн үйлчилгээ үзүүлэгчийн салбарын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх суурь судалгааг Үндэсний эрсдэлийн үнэлгээний Модуль 6.3 (Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн эмзэг байдлын үнэлгээ)-г нэгтгүүлэх саналыг боловсруулж, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хамтын ажиллагааны зөвлөлийн хуралд танилцуулан шийдвэрлүүлсэн.

Мөн Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны А/35 дугаар тушаалаар “Мөнгөн зээлийн үйл ажиллагааны эрсдэлийг үнэлэх дэд ажлын хэсэг (Модуль 6.3)”-ийг байгуулж, ажлын хэсгийн хүрээнд эрсдэлийн үнэлгээний ажлыг нэгдсэн төлөвлөгөөний дагуу гүйцэтгэсэн.

Зөвшөөрлийн цахим системд төрийн мэдээлэл солилцооны ХУР системээс мэдээлэл дуудах боломжтойгоор хөгжүүлэлтийг хийж, Мөнгөн зээлийн системд зээлдэгч иргэнийг ХУР системээр, барьцаалан зээлдэгчийг ДАН системээр нэвтрэлтийг баталгаажуулан цахим системийн хөгжүүлэлтийг хийсэн.

Мөнгөн зээлийн үйл ажиллагааны тайлан хүлээн авах системийг Танилт нэвтрэлтийн систем (ДАН), Төрийн мэдээлэл солилцооны систем (ХУР), ЦЕГ-ын хаясан, гэсэн зүйлийн бүртгэлийн системтэй холбосон.

Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн салбар бүртгүүлэх, оноосон нэр өөрчлөх, хаяг байршил өөрчлөх, хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлтийг орон нутаг болон СЗХ-нд ангилан хүсэлт илгээх маягтыг хөгжүүлж, 150 гаруй хүсэлтийг цахим системээр хүлээн авч шийдвэрлэсэн.

5. ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ САЛБАР

Хадгаламж, зээлийн хоршооны салбарын эрх зүйн орчныг шинэчлэх, ХЗХ-ны салбарт мөрдүүлэх багц журамд оруулах зохицуулалтуудыг Санхүүгийн хоршооны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөлд тусгаж ажилласан.

“Санхүүгийн хоршооны тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төсөлд олон нийтээс санал авах хэлэлцүүлгийг зохион байгуулж, хуулийн төслийг 2025 оны 12 дугаар сард УИХ-д өргөн мэдүүлсэн.

Санхүүгийн хоршооны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөлд Хадгаламж зээлийн хоршоог “Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар”-с чөлөөлөхөөр тусгасан бөгөөд ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан.

Аудитын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.4-т заасны дагуу 2024 оны санхүүгийн тайланг аудитаар баталгаажуулж ирүүлбэл зохих 169 Хадгаламж зээлийн хоршооноос 163 буюу 96.4 хувь нь жилийн эцсийн санхүүгийн тайланд хөндлөнгийн аудитыг хийлгэж ирүүлснийг хянаж хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан.

Хадгаламж зээлийн хоршоонд Монголбанкнаас олгосон тусгай зөвшөөрөл бүхий зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдэд шаардлагатай мэдээллийг өгөх, авах гэрээ байгуулж мэдээлэл солилцох үүргийн хүрээнд Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл олгосон нэр бүхий 2 хуулийн этгээдтэй 109 хадгаламж зээлийн хоршоо хамтран ажиллах гэрээ байгуулсан.

Олон улсын хадгаламж, зээлийн хоршоодын зохицуулагчдын зөвлөл (ICURN)-тэй хамтын ажиллагааг эрчимжүүлэх ажлын хүрээнд Азийн хадгаламж, зээлийн хоршоодын холбоо (ACCU)-оос зохион байгуулсан “Өнөөгийн хэрэгцээ ба ирээдүйн боломж” сэдвээр бүс нутгийн хадгаламж, зээлийн хоршоодын зохицуулалтын тогтолцоог боловсронгуй болгох, ирээдүйн чиг хандлага болон зохицуулалтын байгууллагын сайн туршлагыг хуваалцах уулзалт хийв. Мөн санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг /AFI/-ийн “ЕСАРП”-ийн ажлын хүрээнд “Хүртээмжтэй ногоон санхүүжилт (IGF)–ЖДҮ-дэд зориулсан бүтээгдэхүүн үйлчилгээ”-ний талаар туршлага солилцох бүс нутгийн цахим уулзалтад тус тус оролцож олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлсэн.

6. ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛ, ҮНЭТ ЭДЛЭЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Салбарын зохицуулалтын орчинг зах зээлийн нөхцөл байдал, олон улсын жишигтэй нийцүүлэн холбогдох дүрэм, журам, заавар, аргачлалыг боловсронгуй болгох чиглэлээр Үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалтын сан (REIT)-г Монгол Улсад нэвтрүүлэх, (REIT) сангийн эрх зүйн зохицуулалтын орчныг бий болгох чиглэлээр Ажлын албаны даргын 2025 оны Б/127 тушаалаар ажлын хэсгийг байгуулж, “Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан. УИХ-ын даргын 2025 оны

290 дугаар захирамжаар байгуулагдсан дэд ажлын хэсэгт Монгол Улсад REIT-ийг нэвтрүүлэх боломжийн талаарх саналыг хүргүүлж хамтран санал солилцож ажилласан.

Үл хөдлөх хөрөнгө борлуулахад төлж байгаа 2 хувийн татварыг хүчингүй болгох асуудлаар гаргасан иргэдийн өргөдлийг шийдвэрлэх ажлын хэсэгт СЗХ-ны зохицуулалттай этгээдээр 2022-2024 онд дамжин худалдан борлуулагдсан үл хөдлөх хөрөнгийн үнийн индекс болон хэлбэлзлийн мэдээллийг боловсруулан хүргэж, мэдээлэл өгч хамтран ажилласан.

Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн бүтээгдэхүүний арилжаа эрхлэгчийн салбарын “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний эрсдэлийн үнэлгээ”-г Дэлхийн банкны аргачлалын дагуу хийж гүйцэтгэх дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллаж эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгэсэн.

Тайлант онд Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын салбар болон ҮМҮЧЭТХАЭ-ын салбартай холбоотой нийт 265 хүсэлт ирүүлсэн. Үүнээс үл хөдлөх хөрөнгө зуучлал, үнэт эдлэлийн зохицуулалттай холбоотой 59 /ҮХХЗ-ын үйл ажиллагааны ТЗ-21, ҮМҮЧЭТХАЭ ТЗ-иргэн 35, хуулийн этгээд 3/ асуудлыг хорооны хуралдаанаар, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ хувьцаа эзэмшигчдийн бүтэц бүрэлдэхүүн, эрх бүхий албан тушаалтны өөрчлөлт, хаяг байршлын өөрчлөлт зэрэг бүртгэл, зөвшөөрөлтэй холбоотой 176 хүсэлтүүдийг тухай бүр шийдвэрлэсэн.

7. ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 657 тоот тогтоолоор баталсан “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааны журам”-аас бүртгэх, үйл ажиллагааг түр зогсоох, бүртгэлээс хасахтай холбогдсон болон эрх олголт, тавигдах шаардлага, бүрдүүлэх баримт бичиг зэрэг хэсгүүдэд өөрчлөлт оруулан журмыг боловсруулж, Хорооны 2025 оны 74 дүгээр тогтоолоор “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааны журам”-ыг шинэчлэн баталсан.

Тус салбарт одоогоор виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч 12 этгээд үйл ажиллагаа эрхлэж байна. Дотоодын Виртуал хөрөнгийн зах зээл дээр нийт 23 хувьцаа эзэмшигч бүртгэлтэй байна. Үүний 4 нь 100 хувийн хувьцаа эзэмшигч, 10 нь 50-99 хувийн хувьцаа эзэмшигч, 6 нь 10-49 хувийн хувьцаа эзэмшигч, 3 нь 10-аас доош хувийн хувьцаа эзэмшигч, эдгээрийн 8 нь иргэн, 15 хуулийн этгээд байна. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн арилжааны дэлгэрэнгүй мэдээлэл, хэрэглэгчийн тоо, ханшийн мэдээллийг өдөр бүр системээр авч, удирдлагуудыг мэдээллээр хангаж ажилласан.

Виртуал хөрөнгө болон виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээ (Модуль 11)-г хийж, эрсдэлийн үнэлгээний тайлан болон олон улсын судалгааг эцэслэн, зохицуулалтын орчинг дахин сайжруулах санал боловсруулан ажилласан.

8. СЭНДБОКС ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН

Сэндбокс нь санхүүгийн зах зээлд шинээр нэвтэрч буй бүтээгдэхүүн, үйлчилгээг санхүүгийн зохицуулагч байгууллагын хяналт дор хязгаарлагдмал хүрээнд, бодит орчинд турших боломжийг олгодог инновацыг дэмжсэн зохицуулалтын хэрэгсэл юм.

Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2025 оны 124/75/А86 тоот хамтарсан тушаалаар “Сэндбокс зохицуулалтын орчны журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Журамд “...сэндбоксын орчинд амжилттай туршигдсан бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд шилжүүлэх үйл явц болон зохицуулалтын орчин бүрдэх хүртлэх хугацааны хяналт, хэрэгжүүлэх түр зохицуулалт, сэндбоксын хугацаанд оролцогч үйл ажиллагаагаа түр зогсоох, тусгай зөвшөөрлийн шаардлагаас зайлсхийх зорилгоор сэндбокс зохицуулалтын орчныг ашиглахыг хязгаарлах” зэрэг зохицуулалтуудыг тусгаж өгсөн байна.

Сэндбоксын орчинг олон нийтэд таниулах ажлын хүрээнд Санхүүгийн хүртээмжтэй нийгэмлэгийн Зүүн Европ, Төв Азийн бүс нутгийн уулзалтад оролцож сэндбокс зохицуулалтын орчны туршлага солилцон, бүс нутгийн сэндбокс нэвтрүүлэхэд анхаарах асуудлуудыг хэлэлцэж, туршлага судалсан.

Сэндбоксын орчинд бүтээгдэхүүн, үйлчилгээгээ турших хүсэлтэй хуулийн этгээдтэй уулзалт зохион байгуулж, сэндбоксын орчны талаар зөвлөгөө, мэдээлэл өгч, сэндбокс зохицуулалтын орчин болон финтекийн зах зээлийн хөгжлийн талаар олон нийтэд мэдээлэл хүргэж ажилласан.

Тайлант онд сэндбоксын орчинд бүтээгдэхүүн үйлчилгээ турших нийт 25 хүсэлт ирснээс “Сэндбокс зохицуулалтын орчны журам”-ын шаардлага хангасан 10 хүсэлтийг сэндбоксын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, 9 компаний бүтээгдэхүүн үйлчилгээг сэндбоксын орчинд нэвтрүүлж, 2 компаний 2 үйлчилгээ сэндбоксын орчноос амжилттай гарснаар нийт 4 компаний 6 бүтээгдэхүүн, үйлчилгээ туршигдаж байна.

9. МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын зөвлөмж, стандартын хэрэгжилтийг тайлагнах хүрээнд 2025 оны Явцын тайланг боловсруулж, Ази, номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэг (АНДМУТБ)-т 2025 оны 02 дугаар сард хүргүүлсэн. Тайланд Санхүүгийн зохицуулах хорооноос мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажлын тайланг тусгаж боловсруулан хүргүүлсэн. АНДМУТБ-ын ээлжит чуулга уулзалт 2025 оны 08 дугаар сарын 25-29-ний өдрүүдэд Япон Улсын Токио хотод зохион байгуулагдсан. Чуулга уулзалтад зохион байгуулагч орны урилгаар СЗХ-ны албан хаагч АНУ, Австрали, Япон Улсын зохицуулагч байгууллагуудын төлөөллийн хамтаар панелистаар оролцож, Монгол Улсын мөнгө угаах

болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог үр дүнтэйгээр хэрэгжүүлэх талаар болон виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн бодлого, зохицуулалт, хяналт шалгалтын талаар мэдээлэл өгч, туршлага солилцсон.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний зөвлөлийн 2025 оны ээлжит хурлаар “Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний эрсдэлийн үнэлгээ”-г эхлүүлэхээр шийдвэрлэсэн. Үүнтэй холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны А/76 дугаар тушаалаар үндэсний эрсдэлийн үнэлгээг гүйцэтгэх чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдаж, мөн Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны А/171 дүгээр тушаалаар зохицуулалтын салбар тус бүрийн үнэлгээг гүйцэтгэх дэд ажлын хэсгүүд байгуулагдсан. СЗХ нь нийт 10 модулийн ажлын хэсэгт ажиллаж, 7 салбарын модулийг ахлан ажиллаж байна. Үнэлгээг Дэлхийн банкны аргачлалаар гүйцэтгэж модуль тус бүрийн тайлангуудыг гүйцэтгэж ажилласан.

Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр өндөржүүлсэн хяналтад орсон орны “саарал жагсаалт”-д орсон Холбооны Бүгд найрамдах Ардчилсан Балба Улсын “Шууд хэрэгжилт буюу урьдчилан сэргийлэх арга хэмжээ”-ний ахлах үнэлгээчнээр СЗХ-ны албан хаагч сонгогдон ажиллаж байна.

Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ) болон Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэг (АНДМУТБ)-ийн хамтарсан үнэлгээчин бэлтгэх сургалтуудад СЗХ-с 5 албан хаагч хамрагдаж, олон улсын үнэлгээний багт орж ажиллах эрх авсан. Олон улсын үнэлгээний багийн Шри Ланка Улсын 5 дугаар шатны харилцан үнэлгээг гүйцэтгэх ажиллагаанд СЗХ-ны үнэлгээчин сонгогдож 2026-2027 онд ажиллахаар болсон.

ФАТФ-ын дэргэдэх Виртуал Хөрөнгийн Харилцаа Холбооны Бүлэг (Virtual Asset Contact Group (VACG)-т Ази, Номхон далайн бүс нутгийн 42 улсыг төлөөлөн ажиллаж байгаа бөгөөд холбогдох уулзалтуудад тухай бүр орж мэдээлэл солилцон ажиллаж байна.

Макао улсын хүсэлтээр тус улсын санхүүгийн зохицуулагч байгууллага буюу Төв банк, Санхүүгийн мэдээллийн албатай хамтран “Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын Зөвлөмж 15-тай холбоотой туршлага хуваалцах уулзалт”-ыг 2025 оны 03 дугаар сарын 28-ний өдөр цахим хэлбэрээр зохион байгуулан, 3 сэдвээр илтгэл тавьж, мэдээлэл солилцож ажилласан.

ФАТФ-ын олон улсын стандартыг үр дүнтэй хэрэгжүүлэх, дараагийн харилцан үнэлгээнд бэлтгэх хүрээнд олон улсын туршлагыг судлах, харилцан мэдээлэл солилцох зорилгоор Малайз Улсын Төв банкны Санхүүгийн мэдээлэл, албадан гүйцэтгүүлэх газрын менежер, МУТСТ олон улсын эксперт, үнэлгээчнийг урьж, “ФАТФ-ын шинэчилсэн аргачлалаар харилцан үнэлгээнд амжилттай бэлтгэсэн, үндэсний эрсдэлийн үнэлгээг хэрэгжүүлсэн сайн туршлагад тулгуурласан” сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Сургалтад

МУТСТ хамтын ажиллагааны зөвлөлийн хяналт шалгалтын дэд ажлын хэсэг, холбогдох бусад байгууллагын төлөөлөл болон нийт 200 гаруй оролцогч хамрагдсан.

СЗХ-ны зохицуулалттай салбаруудын мэдээлэх үүрэгтэй этгээдийн Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд зайны болон газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлсэн. Энэ хүрээнд “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам”-ын 4.6-д заасны дагуу зохицуулалттай 8 салбарын мэдээлэх үүрэгтэй этгээдээс хагас жил тутамд эрсдэлийн үнэлгээний асуулгыг авч, эрсдэлийн түвшинг үнэлж ажилласан.

СЗХ-ны зохицуулалттай этгээдийн Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх эрсдэлийн үнэлгээний асуулга"-ыг 2024 оны жилийн эцэс болон 2025 оны хагас жилийн байдлаар нийт мэдээлэх үүрэгтэй этгээдээс хүлээн авч Эрсдэлийн үнэлгээний асуулгыг 2024 оны жилийн эцсийн байдлаар 1,136 этгээд, 2025 оны эхний хагас жилийн байдлаар 1,175 этгээд тус тус 71 хувийн ирцтэйгээр асуулгыг ирүүлсэн.

10. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ, КОМПЛАЙНС

Компанийн засаглалын тогтолцоо үр дүнтэй байх нь компанийн урт хугацааны тогтвортой хөгжлийг хангах суурь нөхцөл юм. СЗХ-ны 145 дугаар тогтоолоор “Компанийн засаглалын кодекс”-ийг шинэчлэн баталж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэнээр хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлжээ. “Компанийн засаглалын кодекс”-ийг боловсронгуй болгох, Кодекс болон үнэлгээний аргачлалд нэмэлт өөрчлөлт оруулах төслийн эхний хувилбарыг боловсруулж, үнэлгээний аргачлалыг зах зээлийн нөхцөл байдал, чиг хандлагыг харгалзан бусад орны сайн жишигт нийцүүлэн сайжруулах” зорилгоор Ажлын албаны даргын 2025 оны А/85 тоот тушаалаар “Дотоодын зөвлөх үйлчилгээ авах гэрээг батлуулж, олон улсын болон гадаадын эрх бүхий байгууллагын гаргасан судалгааг харьцуулан кодекс, үнэлгээний аргачлал”-ыг боловсронгуй болгох төслийг боловсруулсан.

Зохицуулалттай этгээдэд мэдээлэл хүргэх, сурталчлах ажлын хүрээнд “Нийцлийн менежментийн тогтолцоо ISO 37301” стандартыг авах зорилгоор Стандарчлал, хэмжил зүйн газарт "Хамтран ажиллах тухай" 2025 оны 3-1/1942 тоот албан бичгийг хүргүүлж стандартыг албан хэрэгцээнд хүлээн авсан. Дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих, комплайнсын шаардлагыг хангах “Комплайнсын менежментийн тогтолцоо ISO 37301” стандартыг нэвтрүүлэх, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг ажлын албаны дарга 2025 оны 12 сард баталсан. Уг төлөвлөгөөний дагуу “Нийцлийн менежментийн тогтолцоо ISO 37301” стандартын гэрчилгээ олгох модуль сургалтыг Авлигатай тэмцэх газар болон Стандарчлал, хэмжил зүйн газартай хамтран зохион байгуулж, стандартын талаарх танилцуулга мэдээллийг

боловсруулан “Хүртээмжтэй санхүү” сэтгүүлийн 10 дугаарт нийтлүүлэн олон нийтэд мэдээлсэн.

МХБ-д бүртгэлтэй хувьцаат компаниуд болон зохицуулалттай салбарын “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн үнэлгээний нэгдсэн тайланг хагас, бүтэн жилээр боловсруулж, СЗХ-ны цахим хуудас болон фэйсбүүк пэйж хуудсанд байршуулан, олон нийтэд мэдээлсэн.

Зохицуулалттай этгээдүүдийн үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх, чадавхжуулах чиглэлээр Компанийн засаглал, комплайнс” сэдвээр, “Таван толгой” ХК, “Мөнх даатгал” ХХК, “Хаан банк” ХК-ийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнд зориулж “Кодексийн хэрэгжилт, анхаарах асуудал”, МУИС-н Бизнесийн сургуулийн Санхүүгийн тэнхмийн 3-4 дүгээр курсын оюутнуудад “Комплайнс, Сорилт, Боломжууд” сэдвүүдээр тус тус сургалт зохион байгуулсан.

Зохицуулалттай этгээдийн хүний нөөцийг чадваржуулах мэргэжлийн сургалтуудыг салбарын мэргэжлийн холбоодтой хамтран зохион байгуулж, эрх олгох, мэргэшүүлэх сургалтад зохицуулалттай этгээдийн нийт 1072 албан тушаалтан хамрагдсан байна.

1.2.2. ХУУЛЬ ТОГТООМЖИЙН БИЕЛЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ ЧИГ ҮҮРГИЙН ДАГУУ ХИЙСЭН АЖИЛ, ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ:

Хяналт шалгалт зохицуулалтын чиг үүргийн хүрээнд буюу Үнэт цаас, Даатгал, Банк бус санхүүгийн байгууллага, Хадгаламж, зээлийн хоршоо, Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн чиглэл, бусад асуудлаар СЗХ-ны хуралдаанаар 2025 онд нийт 420 асуудал /тусгай зөвшөөрөл-115, сэргээсэн 18, түдгэлзүүлсэн 77, хүчингүй болгосон 80, бодлого зохицуулалтын чиглэлээр -48, бусад 82/-ыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн байна. Үүнээс ҮЦ-142, Даатгал-42, ББСБ-55, ХЗХ-10, ҮХХЗҮЭЗ-58, ХШЗ-88, Бусад-25 асуудлыг хэлэлцүүлсэн.

СЗХ-ны хуралдаанаар шийдвэрлүүлсэн асуудлуудын тогтоол, шийдвэрийг УБЕГ, СТСХ, НХЭГ-т мэдээлэх үүргийг хэрэгжүүлэх, хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих чиг үүргийн хүрээнд төрийн бүх шатны байгууллагуудаас ирүүлсэн санал, мэдээлэл, судалгаа, лавлагааг авч дүгнэлтүүдийг хүргүүлж ажилласан байна.

Зөрчлийн хэрэгт дугаар олгож, 239 гомдолд хамаарах зөрчлийг хянан шийдвэрлэснээс хялбаршуулсан журмаар-188, зөрчлийн хэрэг нээсэн-36, эрүүгийн хэрэг нээсэн-2, хүлээн авахаас татгалзсан 13 байна.

Зайны хяналт:

Тайлант хугацаанд нийт давхардсан тоогоор улирал, сар бүрийн тайлан, мэдээг 8,140 этгээд ирүүлснийг хянан баталгаажуулж, давхардсан тоогоор 578 зохицуулалттай этгээдэд санхүүгийн тайлагналтай холбоотойгоор тайлангийн хариу хүргүүлж, давхардсан тоогоор 7,562 этгээдэд /ҮЦЗЗ-527, ДЗЗ-352, ББСБ-5,610, ХЗХ-448, МУТСТ-625/ зохистой харьцаа, зохицуулалтын

үйлчилгээний хөлс, санхүүгийн тайлан, мэдээтэй холбоотой болон бусад хууль тогтоомж, журмын хэрэгжилтийг хангаж ажиллах талаарх мэдэгдлийг цахимаар болон албан бичгээр хүргүүлэн, тухай бүр хэрэгжилтийг хангуулан ажилласан. Зайны хяналтын хүрээнд улирал, сарын тайлан, мэдээ, асуулгатай холбоотой 62 этгээд /даатгал-5, ББСБ-26, МУТСТ-35/-д Улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлэн биелэлтийг хангуулж, хууль журмын биелэлтийг хангаж ажиллаагүй нэр бүхий 37 этгээд /ҮХЭХЗБ-14, ҮМҮЧЭТХЭАЭ-23/-д дүгнэлт гарган холбогдох саналыг хүргүүлсэн.

Үл хөдлөх эд хөрөнгө зуучлал, үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагааны зохицуулалтын чиглэлээр нэр бүхий 559 этгээдэд /ҮХХЗБ-487, ҮМҮЧЭТХЭАЭ-72/ мэдэгдэл, зөвлөмж, тайлангийн хариу, УБАШ-ыг хүргүүлсэн.

Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагад УБАШ-2, зөвлөмж-379, тайлангийн хариу-50, тусгай зөвшөөрлийг түтгэлзүүлэх мэдэгдэл-37, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай мэдэгдэл 19 хүргэсэн, ҮМҮЧЭТХЭАЭ хуулийн этгээдэд зөвлөмж-36, тайлангийн хариу-13, тусгай зөвшөөрлийг түтгэлзүүлэх мэдэгдэл 17, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай мэдэгдэл-6 хүргэсэн.

Үл хөдлөх эд хөрөнгө зуучлал, Үнэт эдлэлийн зохицуулалтын газраас зохицуулалтын чиглэлээр 3,214 тайлан мэдээг авч хянан баталгаажуулж салбарын нэгтгэлд хамруулсан. Үүний 1,413 санхүүгийн тайлан, 797 зуучлалын мэдээ, 1,004 арилжааны мэдээ байна.

Эрсдэлийн үнэлгээний үр дүн, МҮЭ-ийн эрсдэлийн профайлын мэдээлэлд үндэслэн нийт 685 удаагийн МУТС эрсдэлийн үнэлгээний дүгнэлтийг холбогдох газар, нэгжид тухай бүр хүргүүлж, мэдээллийн урсгалыг хангаж ажилласан.

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн зайны хяналт шалгалтыг хэрэгжүүлэх blockchain analytics систем хэвийн ажиллаж, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн зайны хяналт шалгалтыг хэрэгжүүлэн ажиллажээ. Мөн API системээр виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн арилжааны дэлгэрэнгүй мэдээлэл, хэрэглэгчдийн тоо, ханшийн мэдээлэл зэргийг өдөр бүр авч, хяналт тавин ажиллаж байна.

Эрсдэлийн үнэлгээ, зайны хяналтад үндэслэн нийт 73 мэдээлэх үүрэгтэй этгээдийн үйл ажиллагаанд газар дээрх шалгалтыг гүйцэтгэсэн бөгөөд давхардсан тоогоор нэр бүхий 49 мэдээлэх үүрэгтэй этгээдэд хугацаатай үүрэг даалгавар, УБАШ-6-г тус тус хүргүүлж, 1 Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааг түр зогсоосон.

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн хяналт зохицуулалтын чиглэлээр иргэнээс ирүүлсэн өргөдлийн дагуу нэр бүхий хуулийн этгээдэд зайны хяналт шалгалтыг хэрэгжүүлэн “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааны журам”-д заасан мэдээллийн ил тод байдлыг хэрэгжүүлэхтэй холбоотой зөрчлийг илрүүлж, улсын байцаагчийн албан шаардлагаар зөрчлийг арилгах үүрэг даалгаврыг хүргүүлсэн.

Нэр бүхий Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчтэй холбогдуулан иргэнээс ирүүлсэн гомдлыг шалгаж зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж, торгууль ногдуулж, Тус хэрэгтэй холбогдуулан СЗХ-г төлөөлөн нийслэлийн 3 шатны шүүхээс шийтгэврийг хэвээр үлдээхээр шийдвэлэсэн

Сэндбоксын орчинд туршигдаж буй нийт 6 компаниас 7 хоног, сар, улирлын мэдээллийг татан төвлөрүүлж, зайны хяналтыг тавьж ажилласан.

Газар дээрх хяналт, шалгалт:

Зохицуулалттай этгээдүүдэд газар дээрх шалгалтаар 645 этгээдийн үйл ажиллагаанд шалгалтыг гүйцэтгэн, холбогдох хууль тогтоомжийн дагуу зохих үүрэг даалгаврыг хүргэж, биелэлтийг хангуулсан байна.

Давхардсан тоогоор 280 гадаад валютын арилжаа эрхлэгч ББСБ, нэр бүхий 3 ББСБ, 1 ХЗХ-ны үйл ажиллагаанд үзлэг хийж 143 этгээдэд^{Үнэт цаас 8, Даатгал 10, ББСБ 66, ХЗХ 6, ҮХХЗ-10, ҮМҮЧТХЭАЭ-10, МУТА 35/} УБАШ хүргүүлж, 184 этгээдэд 1,389.2 сая төгрөгийн торгуулийг ногдуулж, хяналт тавьж ажилласан.

Үл хөдлөх хөрөнгө зуучлал, үнэт эдлэлийн зохицуулалтын чиглэлээр 7 ҮХХЗБ, 1 ҮМҮЧЭТХЭАЭ хуулийн этгээдийн үйл ажиллагаанд газар дээрх иж бүрэн шалгалтыг, 81 ҮХХЗБ-ын үйл ажиллагаанд хэсэгчилсэн шалгалт, нийт 89 хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг гүйцэтгэсэн.

Газар дээрх шалгалтад хамрагдсан нэр бүхий 42 хуулийн этгээдэд хугацаатай үүрэг даалгаврыг өгснөөс хуулийн этгээдүүд албан шаардлагад заасан хугацаанд зөрчлөө арилгаж, биелэлтийг ханган ажилласан байна.

Газар дээрх хяналт шалгалтын хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2025 оны өдрийн 85 дугаар тушаалаар баталсан “Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн албатай хамтарсан “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааг үнэлэх газар дээрх хяналт, шалгалтын удирдамж”-ийн дагуу бүртгэлтэй 12 виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдэд шалгалтыг зохион байгуулсан.

Шалгалтаар тэдгээрийн арилжааны самбарт арилжаалагдаж буй дотоод болон гадаад виртуал хөрөнгийн арилжааны хэмжээ, ханш, ханшийн өөрчлөлт, зах зээлийн үнэлгээ, ашиглаж буй систем, санхүүгийн тайлан, эрсдэлийн үнэлгээний тайлан болон бусад холбогдох тайлан, мэдээнд тухай бүр хяналт шалгалтыг хэрэгжүүлж, хянан шийдвэрлэх ажиллагааг гүйцэтгэснээр зөрчлийн хэрэг-1, улсын байцаагчийн албан шаардлага-2, 48 удаагийн хугацаатай үүрэг даалгаврыг хүргүүлж, биелэлтийг тооцож ажилласан.

1.2.3 ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ, ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ, ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ:

Санхүүгийн зохицуулах хороо нь 2025 оны жилийн эцсийн байдлаар өмнөх оны үлдэгдэл 13 хэрэг, шинээр 18 нэхэмжлэл хүлээн авч, 3 нэхэмжлэл шүүхэд гарган нийт 34 хэрэг, маргаанд нэхэмжлэгч, хариуцагчаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож, хариу тайлбар, нотлох баримтыг гарган, хөрөнгө оруулагч үйлчлүүлэгчийн эрх ашгийг тухай бүр хамгаалан ажилласан.

Эрх зүйн ангиллын хүрээнд захиргааны байгууллага, албан тушаалтан тэдгээрийн шийдвэр, үйл ажиллагаатай холбоотой захиргааны хэрэг 31 буюу 91.2 хувийг, иргэний хэрэг 3 буюу 8.8 хувийг эзэлж байна.

Нийт хэрэг маргааны 16 буюу 47.1 хувийг үнэт цаасны салбар, 5 буюу 14.7 хувийг даатгалын салбар, 9 буюу 26.5 хувийг ББСБ-ын салбар, 3 буюу 8.8 хувийг мөнгөн зээлийн үйл ажиллагааны зохицуулалтын салбар, ВХХҮҮ салбар, 1 хэрэг буюу 2.9 хувийг бусад салбарт тус тус хамаарч байна.

Тусгай зөвшөөрөл эзэмшигч, үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагч, харилцагч, үйлчлүүлэгчээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэх чиг үүргийн хүрээнд :

СЗХ-ны албан хэрэг хөтлөлтөд бичгээр ирүүлсэн 670, цахимаар /info@frc.mn, зөвшөөрлийн системээр/ 306, нийт 976 өргөдөл, гомдлыг хүлээн авч тухай бүр шийдвэрлэсэн. Өргөдөл гомдлын 68.6 хувийг бичгээр, 31.4 хувийг цахимаар хүлээн авсан байна.

Санхүүгийн зохицуулах хороо нь ирүүлсэн өргөдөл, гомдлыг, хуулийн хугацаанд хянан шийдвэрлэж, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлсэн бөгөөд 48.7 хувь нь даатгалын үйлчилгээтэй холбоотой байна. Үүнийг салбараар ангилбал:

- 1/ Үнэт цаасны зах зээлийн чиглэлээр: 128 /13.1 хувь/;
- 2/ Даатгалын зах зээлийн чиглэлээр: 475 /48.6 хувь/;
- 3/ Банк бус санхүүгийн байгууллагын чиглэлээр: 207 /21.2 хувь/;
- 4/Хадгаламж зээлийн хоршооны чиглэлээр: 43/4.4хувь/;
- 5/ Мөнгөн зээлийн үйл ажиллагааны чиглэлээр: 46 /4.7 хувь/;
- 6/ ВХҮҮ-ийн зохицуулалтын чиглэлээр: 16 /1.6 хувь/;
- 7/ Бусад зохицуулалтын чиглэлээр: 61/6.1 хувь/;

Хүлээн авсан нийт өргөдлийн дийлэхи хувь нь хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах агуулгатай байна.

Иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх чиг үүргийн хүрээнд:

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.13-д заасан “иргэдэд санхүүгийн мэдлэг олгох ажлыг зохион байгуулах” бүрэн эрхийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

СЗХ-ны бодлого, шийдвэрийг сурталчлах, таниулах, сургалт зохион байгуулахад зохицуулалттай этгээдүүдийг бүрэн хамруулах, хамтран ажиллах чиглэлээр төрийн гүйцэтгэх

зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр ТББ, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх хүрээнд сургалт зохион байгуулан гэрээний хэрэгжилтэд хяналт тавин ажилласан.

Зохицуулалттай салбарт ажиллах боловсон хүчнийг мэргэшүүлэх, санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх сургалтыг тайлант онд нийт 104 удаа зохион байгуулж, 7,362 суралцагчийг хамруулан мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Сургалтыг чиглэлээр багцлан авч үзэхэд эрх олгох сургалтад 2,832^{/43 удаа/} суралцагч, мэргэшүүлэх сургалтад 626^{/28 удаа/} суралцагч, мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх сургалтад 1,696^{/32 удаа/} суралцагч, мөнгөн зээлийн үйл ажиллагааны чиглэлийн сургалтад 2,208^{/цахим 1 удаа/} суралцагчийг тус тус хамруулсан байна.

“Сургалт зохион байгуулах гэрээ” байгуулсан мэргэжлийн холбоодтой хамтран 72 удаагийн сургалт зохион байгуулж 3,488 санхүүгийн зах зээлд оролцогч хамрагдсанаас 2,757 нь тухайн зохицуулалттай салбарт ажиллах болзол, шаардлагыг хангаж гэрчилгээ гардан авч, оролцогчдын мэдээллийг нэгдсэн санд оруулж бүртгэлжүүлсэн.

“Байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ), тогтвортой байдлын тайлагнал” сургалтыг даатгалын компанийн эрх бүхий албан хаагчдад зориулан 2025 оны 05 дугаар сард Монголын тогтвортой санхүүгийн холбоо, Олон улсын санхүүгийн корпорац, Дэлхийн банк хамтран зохион байгуулсан.

Иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр “Хөрөнгийн зах зээл ба 1072 хувьцаа” нээлттэй хаалганы өдөрлөгийг бүсчилж зохион байгуулснаар Баруун бүсийн 4, Төвийн бүсийн 5, Говийн бүсийн 2, Зүүн бүсийн 3 аймаг, нийт 14 аймгийн 10 000 гаруй иргэд мэдээлэл өгсөн.

Монголын даатгалын холбоо, Монголын даатгалын зах зээлийн холбооны гишүүн компаниудад зориулан “Байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ), тогтвортой байдлын тайлагнал” сэдэвт сургалтыг олон улсын байгууллагуудтай хамтран зохион байгуулж даатгалын салбарын удирдах ажилтнуудад БОНЗ болон тогтвортой байдлын тайлагналын чиг хандлага, олон улсын стандарт, сайн туршлагын талаар мэдээлэл өгч, уг тайланг гаргаж хэвших шаардлага, түүний ач холбогдлын талаар онцлон танилцуулсан.

Олон улсын зээлжих зэрэглэл тогтоох байгууллага “AM Best” агентлаг болон “Үндэсний давхар даатгал” ХК-тай хамтран “Introduction to ORSA Requirements”, “Risk-Based Capital (RBC) and Stress Testing”, “AM Best BCRM Building Blocks”, Монгол Улсын даатгалын салбарын зохицуулагчийн чадавхыг бэхжүүлэх сэдэвт сургалтуудыг зохион байгуулсан.

НҮБ хөгжлийн хөтөлбөр "Тогтвортой байдлын тайлагнал, удирдлагын төв" (SDMH) хөтөлбөрөөс зохион байгуулсан “Тогтвортой байдлын тайлагнал” сэдэвт вебинарт даатгалын компанийн удирдах ажилтан болон санхүүгийн мэргэжилтнүүдийг хамруулсан.

Өсвөрийн парламент-2025 хөтөлбөрийн 13 гишүүнээр дамжуулан Нийслэлийн Сүхбаатар дүүргийн ерөнхий боловсролын ахлах ангийн 59 сурагчийг “Санхүүгийн боловсрол” сургалтад хамруулсан байна.

Олон нийтэд зориулсан “Хөрөнгийн зах зээл” сургалтыг 4 удаа танхим болон цахимаар зэрэг зохион байгуулж нийт 597 оролцогч, “Даатгалын ач холбогдол” олон нийтэд зориулсан сургалтыг танхим болон цахимаар зэрэг зохион байгуулж 137 оролцогч, “Мөнгөн зээлийн тухай” олон нийтэд зориулсан сургалтыг танхимаар зохион байгуулж 62 иргэн хамрагдсан.

Олон нийтэд зориулсан 6 сургалт, залуу үед зориулсан 5 арга хэмжээ, орон нутагт 1 сургалт, бизнес эрхлэгчдэд 4 сургалт, захиалгат 2 сургалт, про-боно арга хэмжээг тус тус зохион байгуулсан байна.

Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк, Хадгаламжийн даатгалын корпорац, Боловсролын ерөнхий газартай хамтран ахлах ангийн сурагчдын санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх “LEVEL-UP” хөтөлбөрийг 2025 онд үе шаттай хэрэгжүүлж нийт нийслэлийн 6 дүүрэг, 6 аймгийн 5,033 сурагч, 149 багш хамруулсан байна.

СЗХ-ны бодлого, үйл ажиллагааны талаарх мэдээллээр олон нийтийг нээлттэй, шуурхай тогтмол хангах ажлын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд

СЗХ-ны үйл ажиллагаа, бодлого шийдвэр, санхүүгийн зах зээлийн талаарх нийт 210 мэдээ, ярилцлага, видео контент, постер бэлтгэн хорооны сайт, пэйж, линкедин, твиттер, инстаграм болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээж ажилласан.

Зохицуулалттай салбарын нийт 131 мэдээг боловсруулан сайт, пэйж, линкедин, твиттер, инстаграм болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээсэн.

Орон нутгийн иргэдэд зориулсан 23 мэдээ, видео контент бэлтгэж, сайт, пэйж, линкедин, твиттер, инстаграм болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээсэн.

Ногоон, тогтвортой санхүүжилтийн талаар 23 мэдээ, видео контент бэлтгэн Хорооны сайт, пэйж, линкедин, твиттер, инстаграм болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээсэн.

Салбарын бодлогын зөвлөлийн үйл ажиллагаа, ээлжит хуралдаануудын талаарх нийт 9 мэдээг бичиж, сайт, пэйж, линкедин, твиттер, инстаграм болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээж олон нийтэд нээлттэй мэдээллийг хүргэж ажилласан:

1.3 ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА

Санхүүгийн зохицуулах хороо нь Монгол Улсын санхүүгийн салбарын хөгжлийг олон улсын түвшинд хүргэх, бүс нутгийн санхүүгийн интеграцид нэгдэх үйл явцыг эрчимжүүлэх зорилтын хүрээнд гадаад орны санхүүгийн зохицуулагч байгууллагууд, олон улсын хамтын нийгэмлэгийн байгууллагууд, мэргэжлийн холбоод болон хөгжлийн донор байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлж ажилласан байна.

Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг /AFI/-ийн “ЕСАРГ”-ийн ажлын хүрээнд “Хүртээмжтэй ногоон санхүүжилт (IGF)–ЖДҮ–дэд зориулсан бүтээгдэхүүн үйлчилгээ”-ний талаар туршлага солилцох бүс нутгийн цахим уулзалтад хамтын ажиллагааг өргөжүүлж ажилласан.

СЗХ-ноос Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг /AFI/-ийн “Тогтвортой, ногоон санхүүжилтийн бодлого ба хэрэгжилт” уулзалт сургалтад оролцож “Дижитал санхүүгийн үйлчилгээг ногоон санхүүжилт болон хүйсийн мэдрэмжтэй бодлого боловсруулан” хэрхэн ашиглаж байгаа талаарх туршлагыг Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг /AFI/-ийн гишүүн орнуудад танилцуулан туршлага солилцож ажилласан.

Туркийн хамтын ажиллагаа, зохицуулах агентлаг/TİKA/-тай хамтран ажиллах тухай хүсэлтийг албан бичгээр хүргүүлж, Канадын “Toronto center” байгууллагатай хамтран ажиллах боломжийн талаар тус байгууллагаас ирүүлсэн санал болон үйл ажиллагааны талаар, чадавх бэхжүүлэх сургалтын хөтөлбөрүүдэд хэрхэн хамрагдах талаар санал солилцож ажилласны үр дүнд тус байгууллагаас 2026 оны сургалтын хөтөлбөрийн танилцуулгыг ирүүлсэн.

СЗХ нь КАРЕК буюу /Central Asia Regional Economic Cooperation буюу Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны хөтөлбөр/-ийг хэрэгжүүлэгч орнуудын цахим уулзалтыг 2025 оны 07 дугаар сард зохион байгуулсан ба уулзалтад Пакистан, Узбекистан улсын төв банк болон Азийн хадгаламж, зээлийн хоршоодын холбоо /ACCU/, МХЗХҮХ-оос төлөөлүүд оролцож ХЗХ-дод тулгарч байгаа жендер болон ногоон санхүүгийн бүтээгдэхүүнтэй холбоотой өөрсдийн туршлагыг солилцсон.

Санхүүгийн зохицуулах хорооны дарга АХБ-ны Монгол Улс дахь суурин төлөөлөгчтэй уулзалт зохион байгуулж, АХБ-ны “Эмэгтэй бизнес эрхлэгчдэд зориулсан ногоон болон дижитал эдийн засгийг дэмжих” төслийн хүрээнд хийгдэх ажилд санал хүргүүлж, АХБ-аас зохион байгуулсан “Жендер ба хөгжил” бодлогын хэлэлцүүлэгт оролцож ажилласан.

1.4 ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА

1.4.1 ХҮНИЙ НӨӨЦ

Санхүүгийн зохицуулах хорооны бүрэн эрх, үүргийг хэрэгжүүлэх болон байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор нийт 190 ажилтан, албан хаагчтайгаар ажил үүргээ гүйцэтгэсэн байна. Тайлант хугацаанд шинээр болон хүүхэд асрах, сургалтын чөлөөнөөс 33 албан хаагч томилогдож, 13 албан хаагч ажлаас чөлөөлөгдсөн байна.

Хүснэгт 2. СЗХ-ны албан хаагчдын боловсрол, нас, хүйсийн мэдээлэл

Төрийн албан тушаалын Ангилал			Боловсрол				Нас/Хүйс	
			Боловсролын зэрэг		Мэргэжил		Нас	
Төрийн тусгай албан хаагч	3		Доктор	3	Санхүү, эдийн засаг, нягтлан бодох бүртгэл	109 /57%/	20-25	24

Төрийн захиргааны албан хаагч	179	Магистр	74	Эрх зүйч	27/14%/	26-35	67
Төрийн үйлчилгээний албан хаагч	4	Бакалавр	112	Бусад мэргэжил	54/29%/	36-45	61
Гэрээт ажилтан	4	Бүрэн дунд	1			46-60	38

✿ Эмэгтэй-70%, эрэгтэй 30%,

✿ 25 доош-13%, 26-35 -35%, 36-45 -32%, 46 дээш-20%,

✿ доктор-1.6%, магистр-38.9%, бакалавр-59.0%, бүрэн дунд-0.5%

Албан хаагчдын дундаж наслалт 37 бөгөөд нийт албан хаагчдын 70 хувийг эмэгтэй, 30 хувийг эрэгтэй албан хаагчид эзэлж байна.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 100 дугаар захирамжаар 2 албан хаагчид эрхэлсэн түшмэлийн зэрэг дэвийг шинээр, 4 албан хаагчид ахиулан олгосноос гадна СЗХ-ны даргын 42 дугаар тушаалаар 3 албан хаагчид ахлах түшмэлийн зэрэг дэвийг, 14 албан хаагчид дэс түшмэлийн зэрэг дэвийг шинээр, 31 албан хаагчид ахлах түшмэлийн, 11 албан хаагчид дэс түшмэлийн зэрэг дэвийг ахиулан олгосноор нийт албан хаагчдын 122 буюу 67.4 хувь нь зэрэг дэвтэй болжээ.

Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх зорилгоор Төрийн албаны төв байгууллагад тусгай шалгалтын захиалгыг Удирдах албан тушаалын 1 (тэргүүн түшмэл 1), гүйцэтгэх албан тушаалын 11 (эрхэлсэн түшмэл 3, ахлах түшмэл-5, дэс түшмэл 3) ажлын байрыг нөхөхөөр хүргүүлснээр 12 ажлын байрны сул орон тоог амжилттай нөхөж Төрийн албаны зөвлөлийн шийдвэрийн дагуу албан хаагчдыг тухайн албан тушаалд томилжээ.

Төрийн албан хаагчийн шалгалтад хамрагдаж тэнцсэн нэр бүхий 2 албан хаагч төрийн захиргааны албанд шинээр томилогдож, тангараг өргөх ажлыг зохион байгуулсан байна.

СЗХ-ны албан хаагчдыг чадавхжуулах, мэдлэг чадварыг дээшлүүлэх чиглэлээр Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх Удирдлагын академийн багц сургалтад 36 албан хаагч хамрагдаж төгссөн.

Нийт албан хаагчдыг сургаж мэргэшүүлэх ажлын хүрээнд 4 төрлийн сургалтад давхардсан тоогоор 267 албан хаагч хамрагдаж, 76 албан хаагч олон улсын сургалт, арга хэмжээнүүдэд оролцсон байна.

"Төрийн албаны хүний нөөцийн удирдлага мэдээллийн тогтолцоо" цахим системийг хөгжүүлэн, төрийн байгууллага, албан хаагчийн мэдээлэл бүхий их өгөгдлийн санг бий болгож албан тушаалын тодорхойлолтыг цахим системд нэвтрүүлж, шалгалтын системтэй холбогдох суурь бэлтгэл ажлыг ханган, СЗХ-ны батлагдсан бүтэц, орон тоо, албан тушаалын тодорхойлолтыг системд оруулж, Төрийн албан хаагчийн бүртгэлийг үнэн зөв хөтлөж ажилласан.

Монгол Улсын Ёс зүйн хорооноос зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн эрсдлийн үнэлгээ”-нд СЗХ нь 129 албан хаагчийг хамруулан эрсдэлийн үнэлгээг хийлгэж холбогдох тайланг хүргүүлж ажилласан.

1.4.2 САНХҮҮ, ТӨСВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуулиар СЗХ-ны багцад 20,920.4 сая төгрөгийн төсөв зарцуулахаар баталсан байна.

Нийт батлагдсан төсвийн 81 хувийг улсын төсвийн санхүүжилтийн орлого, 19 хувийг үндсэн үйл ажиллагааны орлого буюу зохицуулалтын үйлчилгээний хөлсний орлогоор бүрдүүлэхээс, гүйцэтгэлээр 77:23 харьцаатайгаар биелж, байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулах санхүүгийн нөөцөөр хангаж ажиллажээ.

Нийт орлогын гүйцэтгэл 20.422.9 /санхүүжилтийн орлого-15,753.6, ЗҮХ-4,669.0/ сая төгрөг бөгөөд 2025 онд 20,920.4 сая төгрөгийн зардлыг зарцуулахаар батлагдаж, гүйцэтгэлээр 18,378.2 сая төгрөг зарцуулж, батлагдсан төсвийг 12.2 хувь буюу 2,542.2 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Тайлант хугацаанд үндсэн үйл ажиллагааны орлого 4,000.0 сая төгрөг төвлөрүүлэхээс 4,669.0 сая төгрөг төвлөрч орлогын гүйцэтгэлийн биелэлт 669.0 сая төгрөгөөр давсан буюу 116 хувийн гүйцэтгэлтэй байна.

Нийт орлогыг ангилан харуулбал:

- Банк бус санхүүгийн байгууллагын салбар 1,511.3 сая төгрөг буюу 32 хувь
- Даатгалын салбар 1,079.3 сая төгрөг буюу 22 хувь
- Үнэт цаасны салбар 1,759.7 сая төгрөг буюу 38 хувь
- Хадгаламж, зээлийн хоршооны салбар 42.1 сая төгрөг буюу 0.8 хувь
- Үл хөдлөх хөрөнгө зуучлал, үнэт эдлэлийн байгууллага 74.6 сая төгрөг буюу 2 хувь
- Виртуал хөрөнгө 167.3 сая төгрөг буюу 4 хувь
- Мөнгөн зээлийнүйл ажиллагаа эрхлэгч 33.6 сая төгрөг буюу 1 хувь
- Бусад 0.2 сая төгрөг 0.01 хувь

Хүснэгт 3. Төсвийн гүйцэтгэлийн мэдээ
Тайлант хугацаа: 2025 оны 12 сарын 31
/мян.төг/

Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өөрчлөлт	Гүйцэтгэлд эзлэх хувь	Нийт гүйцэтгэлд эзлэх хувь
			хэмнэлт(-) хэтрэлт(+)		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	20,920,456.9	18,378,249.8	(2,542,207.1)	87.8%	100.0%
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	20,920,456.9	18,378,249.8	(2,542,207.1)	87.8%	100.0%
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	20,064,452.6	17,542,989.8	(2,521,462.8)	87.4%	95.5%
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	20,064,452.6	17,542,989.8	(2,521,462.8)	87.4%	95.5%
Цалин хөлс болон нэмэгдэл суутгал	14,718,993.2	13,946,369.4	(772,623.8)	94.8%	75.9%
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,806,336.7	1,687,344.5	(118,992.2)	93.4%	9.2%
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	66,276.6	64,062.3	(2,214.3)	96.7%	0.3%

Хангамж, бараа материалын зардал	190,395.7	56,100.8	(134,294.9)	29.5%	0.3%
Эд хогшил, урсгал засварын зардал	6,131.9	1,086.6	(5,045.3)	17.7%	0.01%
Томилолт, зочны зардал	97,995.4	85,689.2	(12,306.2)	87.4%	0.5%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,159,818.1	1,695,268.0	(1,464,550.1)	53.7%	9.2%
Бараа үйлчилгээний бусад зардал	18,505.0	7,069.2	(11,435.8)	38.2%	0.04%
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	612,604.3	591,860.0	(20,744.3)	96.6%	3.2%
Засгийн газрын урсгал шилжүүлэг	447,682.5	447,682.5	-	100.0%	2.4%
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	132,935.6	132,935.5	(0.1)	100.0%	0.7%
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	31,986.2	11,242.0	(20,744.2)	35.1%	0.1%
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДАЛ	243,400.0	243,400.0	-	100.0%	1.3%
Дотоод эх үүсвэрээр	243,400.0	243,400.0	-	100.0%	1.3%
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	20,920,456.9	20,422,999.3	(497,457.6)	97.6%	100.0%
Үндсэн үйл ажиллагааны орлого	4,000,000.0	4,669,000.6	669,000.6	116.7%	22.9%
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	16,920,456.9	15,753,648.6	(1,166,808.3)	93.1%	77.1%
Улсын төсвөөс санхүүжих	16,677,189.8	15,753,648.61	(923,541.2)	94.5%	77.1%
Төвлөрүүлэх шилжүүлэг		2,044,749.4	2,044,749.4		10.0%
Бусад орлого		350.0	350.0		

Нийт зардлын 76 хувийг цалин хөлс болон нэмэгдэл суутгал, 9.2 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж, 9 хувийг ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, 3.2 хувийг урсгал шилжүүлэг, 1.3 хувийг хөрөнгийн зардал, 3.5 хувийг бусад зардалд тус тус зарцуулсан байна.

Батлагдсан төсөвтэй харьцуулбал цалин хөлс болон нэмэгдэл суутгал 772.6 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 11.4 сая, урсгал шилжүүлэг 20.7 сая, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж 0.1 сая төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Хүснэгт 4. Төсвийн гүйцэтгэлийн шинэжилгээг хүснэгтээр харуулбал:
/мян.төг/

№	Үзүүлэлт	2024 он		2025 он		Оөрчлөлт /Гүйцэтгэлээр/ бууралт (-) өсөлт (+)	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Гүйцэтгэлд эзлэх хувь
	НИЙТ ЗАРДЛЫН ДҮН	14,727,636.8	11,692,049.2	20,920,456.9	18,378,249.8	(2,542,207.1)	100%
1	Бараа ажил үйлчилгээний зардал	13,304,094.6	10,389,486.1	20,064,452.6	17,542,989.8	(2,521,462.8)	95.5%
2	Урсгал шилжүүлэг	531,042.2	479,330.5	612,604.3	591,860.0	(20,744.3)	3.2%
3	Хөрөнгийн зардал	892,500.0	823,232.6	243,400.0	243,400.0	-	1.3%

Нийт зардлын дүн өмнөх оноос 6,686.2 сая төгрөг буюу 36 хувиар өсч зарцуулагдсан нь бараа, ажил үйлчилгээний зардалд цалин хөлс болон нэмэгдэл суутгал 6,570.9 сая төгрөгөөр нэмэгдэж, урсгал шилжүүлэг 112.5 сая төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлтүүдээс хамааралтай байна.

Улсын төсөвт 41.5 сая төгрөгийн тэмдэгтийн хураамжийн орлого, 1,429.6 сая төгрөгийн торгуулийн орлогыг төвлөрүүлж ажилласан.

1.4.3 ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА, ХӨГЖИЛ

Санхүүгийн зохицуулах хороо нь санхүүгийн салбарын бодлого, зохицуулалт, хяналтын талаар шийдвэр гаргахдаа судалгаа, шинжилгээг үндэслэн тодорхойлж байна. Олон нийтийг санхүүгийн болон санхүүгийн бус бизнесийн салбарын талаар бодит тоон мэдээллээр хангах, СЗХ-ны баримталж буй бодлого, зохицуулалт, цаг үеийн арга хэмжээнүүдийг цаг алдалгүй түгээх, санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх хүрээнд дараах ажлуудыг гүйцэтгэжээ. Үүнд:

1. СЗХ-ны зохицуулалтын Хөрөнгийн зах зээл, ХААБ, Даатгал, ББСБ, ХЗХ, ҮХЭХЗ, ҮМҮЧЭТХЭАЭ-ийн санхүүгийн нэгтгэл тайлангийн голлох тоон үзүүлэлтийг улирлаар, цаг хугацааны эрэмбээр мэдээллийн сан үүсгэж СЗХ-ны цахим хуудас <http://www.frc.mn/>-ны тайлан мэдээний “Бюллетень” талбарт байршуулсан;

2. СЗХ-ны зохицуулалтын санхүүгийн салбар болох хөрөнгийн зах зээл, даатгалын зах зээл, ББСБ, ХЗХ, мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч, ЗБДС, үл хөдлөх эд хөрөнгө зуучлал, үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгч, сэндбокс зохицуулалтын орчин,

Түүнчлэн ВХҮҮ-ийн салбарын улирлын санхүүгийн нэгтгэл тайлангийн голлох тоон үзүүлэлт болон бодлого зохицуулалтын хүрээнд хууль, эрх зүйн орчин, хамтын ажиллагаа, хурал, семинар, уулзалт зэргийг нэгтгэн “Санхүүгийн салбарын улирлын тойм” нэртэйгээр боловсруулан нийтлүүлсэн ба инфографикт хэлбэрт оруулж СЗХ-ны албан ёсны цахим хуудас <http://www.frc.mn/>-нд тухай бүр байршуулж олон нийтийн хүртээл болгосон;

- ✚ 2024 оны тойм /2025.02.14/;
- ✚ 2025 оны I улирлын тойм /2025.05.15/;
- ✚ 2025 оны II улиралын тойм /2025.08.16/;
- ✚ 2025 оны III улиралын тойм /2025.11.15/

3. Макро эдийн тойм, олон улсын болон Монголын хөрөнгийн зах зээлийн голлох тоон үзүүлэлт, үнэт цаасны зах зээлийн арилжааны мэдээ, уул уурхайн бүтээгдэхүүний болон хөдөө аж ахуйн биржийн арилжааны мэдээ, албан журмын даатгал, зээлийн батлан даалтын сан, сэндбоксын зохицуулалтын орчинд туршигдаж буй бүтээгдэхүүн, үйлчилгээ, ВХҮҮ-ийн арилжаа зэрэг сарын голлох тоон үзүүлэлтүүдийг сар бүрийн 10-нд нэгтгэн боловсруулж, “Санхүүгийн зах зээлийн сарын тойм” нэртэйгээр цахим хэлбэрээр СЗХ-ны албан ёсны цахим хуудас <http://www.frc.mn/>-нд байршуулж олон нийтийн хүртээл болгосон. Үүнд:

- ✚ 2025 оны I улиралд нийт 3 удаа;
- ✚ 2025 оны II улиралд нийт 3 удаа;
- ✚ 2025 оны III улиралд нийт 3 удаа;

✦ 2025 оны IV улиралд нийт 3 удаа.

4. Монголын хөрөнгийн биржүүд дээрх арилжааны дүн, ширхэг, үнэт цаасны зах зээлийн үнэлгээ, топ 20-ын индекс, Уул уурхайн бараа, түүхий эдийн биржийн арилжаа, ВХҮҮ-ийн салбар, биржийн бус зах зээл дээр хийгдсэн арилжаанууд, сэндбокс зохицуулалтын орчинд туршигдаж буй бүтээгдэхүүн, олон улсын хөрөнгийн бирж дээрх арилжааны голлох үзүүлэлтүүдийг батгаасан “Санхүүгийн зах зээлийн 7 хоногийн мэдээ” нэртэйгээр боловсруулан, УИХ-ын Ерөнхийлөгчийн тамгын газар, болон СЗХ-ны удирдлагуудад цахим хэлбэрээр илгээж, мэдээллээр тогтмол хангаж ажилласан. Үүнд:

- ✦ 2025 оны I улиралд нийт 13 удаа;
- ✦ 2025 оны II улиралд 13 удаа;
- ✦ 2025 оны III улиралд нийт 13 удаа;
- ✦ 2025 оны IV улиралд 13 удаа.

5. СЗХ-ны сар бүр эрхлэн гаргадаг “Хүртэмжтэй санхүү” сэтгүүлийг сар бүр бэлтгэн хэвлүүлсэн;

6. СЗХ-ны хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, бодлого шийдвэр, санхүүгийн зах зээлийн талаарх мэдээллийг Хорооны цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр тухай бүрд нь шуурхай түгээж ажилласан;

7. СЗХ нь Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 “Хороо хуулийн хэрэгжилт, түүнчлэн өөрийн санхүүгийн болон үйл ажиллагааныхаа талаар жил тутам Улсын Их Хуралд тайлагнана.” гэж заасны дагуу СЗХ-ны 2025 оны үйл ажиллагааны тайланг нэгтгэн боловсруулж нийтлүүлсэн байна.

1.4.4 МЭДЭЭЛЛИЙН АВТОМАТЖУУЛАЛТ

Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2023 оны 330 дугаар тушаалаар “Мэдээллийн технологи, кибер болон аюулгүй байдлын үйл ажиллагааны журам”-ыг, 2025 оны 158 дугаар тушаалаар “Мэдээллийн аюулгүй байдлын бодлого”-ыг баталж, мөрдөн ажиллаж байна.

Мэдээллийн аюулгүй байдлын аудитыг “Систем центр” ХХК -аар гүйцэтгүүлэн, тайланг хүлээн авч, тайлангийн хурлыг 2025 оны 02 дугаар сард зохион байгуулсан. Мэдээллийн аюулгүй байдлын аудитын зөвлөмжийн дагуу удирдлагын нэгдсэн систем (active director) дээрх хэрэглэгчийн бүртгэлийг майкрософт оффис 365 системийн хэрэглэгчийн эрхтэй холбож нэгдсэн удирдлагаар хангах ажлын хүрээнд нийт албан хаагчдын эрхийг шалгаж, шаардлагатай өөрчлөлтүүдийг хийж хэвийн ажиллагааг хангаж, гарсан асуудлуудыг тухай бүр шийдвэрлэсэн.

Албаны цахим шууданд давхар хамгаалалт (2FA authentication)-ыг идэвхжүүлж үйл ажиллагаанд нэвтрүүлсэн.

Зөвшөөрлийн цахим систем дээр төрийн мэдээлэл солилцооны систем ХҮР системээс мэдээлэл дуудах боломжтой болгон хөгжүүлэлт хийсэн.

СЗХ-ны Ажлын албаны даргын 2025 оны А/05 дугаар тушаалаар Мэдээлэл технологийн үйлчилгээний гэрээг “Бид технологи” ХХК-тай байгуулж, Үндэсний дата товд шилжүүлэх ажлын төлөвлөгөөг хамтран боловсруулж байна.

Мөнгөн зээлийн системд зээлдэгч иргэнийг ХУР системээр, барьцаалан зээлдэгчийг ДАН системээр нэвтрэлтийг баталгаажуулан ашиглаж байгаа.

Мөнгөн зээлийн үйл ажиллагааны тайлан хүлээн авах систем нь Танилт нэвтрэлтийн систем (ДАН), Төрийн мэдээлэл солилцооны систем (ХУР), ЦЕГ-ын хаясан гээсэн зүйлийн бүртгэлийн системтэй холболт хийгдсэн.

Зохицуулалтын байгууллагуудын үйл ажиллагаа эрхлэх зовшоорлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, үйл ажиллагаа нэмж эрхлэх, салбар нэгж байгуулах, оноосон нэр, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувыцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах болон бусад бүртгэлийн асуудлыг хянаж шийдвэрлүүлэхэд системийн хэвийн ажиллагааг ханган ажиллажээ.

1.4.5 АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТ

СЗХ-ны албан хэрэг хөтлөлт, архивын ажлыг Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”, “Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам”-ын дагуу хөтлөн явуулж байна. Албан хэрэг хөтлөлтийг заавар журмын дагуу хөтлөн онцгой нөхцөл байдал үүссэн үед төрийн болон албаны нууцыг хамгаалах төлөвлөгөө, Хорооны албаны нууцын жагсаалт, нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг шинэчлэн боловсруулж хууль, журмын дагуу ТЕГ-т хүргүүлэн санал авч Хорооны даргын 2025 оны 304 дүгээр тушаалаар шинэчлэн баталсан.

Хорооны үйл ажиллагаанд хамаарах төрийн нууцын жагсаалтад хамрагдсан баримтыг шинэчлэн, хууль тогтоомжийн нийцлийг хянан дүгнэлтийг ТЕГ-т хүргүүлсэн. Шинээр ажилд орох, гэрээгээр, дадлагаар ажиллах нийт 56 албан хаагчаар */Дадлагаар ажилласан 16, гэрээгээр ажилласан 16 мунээр ажилд орсон 24 албан хаагч/* нууцын баталгаа гаргуулан хууль журмыг танилцуулсан.

СЗХ-ны дотоод үйл ажиллагааны цаасан баримт бичгийг багасгах зорилгоор Албан хэрэг хөтлөлтийн цахим системийг 2025 оны 10 дугаар сард дотоод үйл ажиллагаанд нэвтрүүлсэн. Тус системийг нэвтрүүлснээр механик ажиллагааг багасгах, баримт бичгийн бүртгэлийн картыг цахимжуулж, цаасаар бичиг цохдог ажиллагааг системээр гүйцэтгэх боломжтой болгосон. Мөн албан хаагчид тогтоол, тушаал, албан бичгийг цаасаар хянуулж цохуулдаг процессыг цахимаар хянуулж, баталгаажуулан бланклуулах боломжтой болсон.

СЗХ-нд байгууллага, иргэдээс ирүүлсэн 9,973 албан бичиг, 976 өргөдөл, гомдлыг програмд бүртгэж, 1,080 танилцуулах хуудас, хяналтын картыг 2,750 албан бичиг болон өргөдөл гомдолд нээж удирдлагад танилцуулж холбогдох газарт хүргүүлж, гадагш явуулсан 4,559 албан бичгийг индексжүүлэн, дугаарлаж бүртгэлийн програмд бүртгэсэн.

Архивын ерөнхий газарт Архивын баримтын нэр төрөл, хадгалах хугацааны үлгэрчилсэн болон салбарын жагсаалтад 2025 оны 3/609 тоот албан бичгээр санал хүргүүлсэн. Хорооны нийт албан хаагчдад албан хэрэг хөтлөлт, архивын үйл ажиллагааны нийтлэг журам, заавар, тавигдах стандарт чиглэлээр танхимын сургалт авах тухай хүсэлтийг Нийслэлийн архивын газарт хүргүүлсэн ба сургалтыг “Баримт бичгийн стандарт”, “Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам” сэдвээр 2025 оны 09 дүгээр сард зохион байгуулсан. Тайлант хугацаанд 2025 онд хөтлөгдөж дууссан архивын баримтыг зохион байгуулалтын нэгж ажилтнуудаас хуваарийн дагуу хүлээн авч, хадгаламжийн санд, хадгаламжийн нэгжийг байршуулжээ.

Зөвшөөрлийн цахим системээр Хорооны зохицуулалттай салбарын шинэ тусгай зөвшөөрлөөс бусад бүртгэл зөвшөөрөлтэй холбоотой хүсэлтийг 2025 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн зөвхөн цахимаар авч нийт 16,600 хүсэлт шийдвэрлэсэн байна.

1.4.6 ДОТООД АУДИТ

Санхүүгийн зохицуулах хорооны Дотоод аудитын нэгжийг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэгт нийцүүлэн, байгууллагын бүтэцэд Төсвийн ерөнхийлөн захирагчийн удирдлагад хамааруулан баталсан байна.

Монгол Улсын хууль тогтоомжоор дотоод аудитын үйл ажиллагааг санхүүгийн үйл ажиллагаанд чиглүүлэн зохицуулсан байдаг ч тус нэгж нь чиг үүрэг, ажлын цар хүрээг санхүүгийн хяналт шалгалтаар хязгаарлахгүйгээр Олон улсын стандартад нийцүүлэн хэрэгжүүлжээ. Олон улсын мэргэжлийн практикийн хүрээнд дотоод аудитын үндсэн зорилго, хамрах хүрээг “байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн хараат бус, бие даасан, бодитойгоор баталгаажуулах, зөвлөх үйлчилгээ” гэж тодорхойлсон байдаг. Иймд Дотоод аудитын нэгж нь байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн эрсдлийн удирдлага, дотоод аудитыг хэрэгжүүлж, бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнг нэмэгдүүлэх ажлыг нэгтгэн зохион байгуулах үүрэгтэйгээр ажилласан байна.

Дотоод аудитын зорилго, үндсэн зарчим, стандартын дагуу Эрсдэлд суурилсан дотоод аудитын төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж, эрсдэлтэйд тооцогдсон объектыг сонголтод хамруулан, Санхүүгийн зохицуулах хорооны даргын баталсан удирдамжийн дагуу чиг үүрэг, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, үйл ажиллагаа нь холбогдох хууль тогтоомжид нийцэж буй эсэхэд Санхүүгийн, Гүйцэтгэлийн, Нийцлийн аудитыг хийж дүгнэлт, зөвлөмж өгсөн. Мөн байгууллагын болон нэгжүүдийн гүйцэтгэлийн тайлан, үйл ажиллагааны үр дүн, бодлогын баримт бичиг, дээд газрын тогтоол, шийдвэр, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийжээ.

Дотоод аудитын ажлын тайлангаар 2025 онд 140 зөрчилд хамаарах 78 зөвлөмж, 8 албан даалгаврыг хүргүүлж, бислэлтэд хяналт тавьж ажилласан. Тосвийн ерөнхийлөн захирагчийн баталсан дотоод аудитын нэгжийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө нь үр дүнтэй хэрэгжсэн бөгөөд байгууллагын дотоод аудитын үйл ажиллагааг Дотоод аудиторын Олон Улсын Институтээс гаргасан тунхаглалууд, Дотоод аудитын мэргэжлийн практикийн үндсэн зарчмууд, Ёс зүйн дүрэм, Дотоод аудитын Мэргэжлийн Практикийн Олон Улсын стандартад нийцүүлэн хэрэгжүүлж, ажлын баримтуудыг боловсруулан, зөвлөмж хүргүүлэн ажилласан байна.

ХОЁР. ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛД ХИЙХ ДҮН ШИНЖИЛГЭЭ БА ХАРЬЦУУЛАЛТ

Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтад хамаарах санхүүгийн салбарын зах зээлийн үнэлгээ болон нийт хөрөнгийн дүн нь 2025 онд ДНБ-ний 26.8 хувьтай тэнцэж байгаа бөгөөд салбар тус бүрээр авч үзвэл Хөрөнгийн зах зээл 15.4 хувь, Даатгалын зах зээл 0.9 хувь, Банк бус санхүүгийн байгууллага 10.1 хувь, Хадгаламж, зээлийн хоршоо 0.4 хувийг тус тус эзэлж байна.

САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭХ САЛБАРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ТАЛААР ДУРЬДВАЛ:



ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ:

- Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийн хүрээнд хөрөнгийн зах зээлд 2025 оны жилийн эцсийн байдлаар нийт 634 ^{/Хувьцаат компани-308, Үнэт цаасны компани-52, бусад-274/} зохицуулалттай этгээд үйл ажиллагаа эрхэлж байна;
- Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 13.9 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.9 их наяд төгрөгөөр буюу 6.6 хувиар өссөн;
 - Хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааны хорвох чадвар 2.1 хувь болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.4 пунктээр өссөн;
 - ҮЦК-уудын нийт хөрөнгө 2025 оны жилийн эцсийн байдлаар 273.0 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 197.6 тэрбум төгрөгөөр буюу 42.0 хувиар буурсан байна;
 - Тайлант хугацаанд нийт 1,315,5 тэрбум төгрөгийн үнэт цаасны арилжаа хийгдсэн нь өмнөх оны мөн үеэс 16.7 дахин, 2021 оноос 7.0 хувиар буурсан үзүүлэлттэй бөгөөд үүнээс 287.3 тэрбум төгрөг буюу 21.8^{/0.9 хувь буурсан/} хувийг хувьцаа, 323.6.1^{/33.2 дахин өссөн/} тэрбум төгрөг буюу 24.6 хувийг компанийн бонд, 372.1^{/2.2 дахин өссөн/} тэрбум төгрөг буюу 28.3 хувийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, 188.0^{/2.2/ дахин өссөн/} тэрбум төгрөг буюу 14.3 хувийг хөрөнгө оруулалтын сан, 144.6 тэр бум төгрөг буюу 11.0 хувийг Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжаа тус тус бүрдүүлсэн;

- Ашигт ажиллагаа 44.3 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 15.8 тэрбум төгрөгөөр буюу 55.4 хувиар өссөн;
- Топ 20 индекс 54,478.17 нь өмнөх онтой харьцуулахад 3,181.7 нэгжээр буюу 6.2 хувиар өссөн;
- Хөдөө аж ахуйн биржээр нийт 1,039.6 тэрбум төгрөгийн бараа бүтээгдэхүүн арилжаалагдсан нь өмнөх оны мөн үеэс 43.7 тэрбум төгрөгөөр буюу 4.4 хувиар өссөн;
- ХААБ-ын нийт хөрөнгө 2025 онд 4.8 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оноос 0.1 тэрбум буюу 2.1 хувиар өссөн;
- Биржийн бус зах зээлийн арилжаанд оролцох эрхтэй шууд оролцогч нийт 39/давхардсан тоогоор андеррайтер 25, дилер 25, брокер 31, ХОС 6 компани, шууд бус оролцогч хувь хүн 5,226, хуулийн этгээд 471/ байна. Тайлант онд нийт 125 үнэт цаас гаргагчийн нийт 2.4 их наяд төгрөгийн болон 84.0 сая ам.долларын үнийн дүн бүхий өрийн хэрэгслийг бүртгэж, үнэт цаас гаргагчийн зүгээс 1.6 их наяд төгрөг, 63.9 сая ам.долларыг тус тус амжилттай татан төвлөрүүлжээ.
- Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны хувьд 2025 оны арилжаагаар 619 удаагийн арилжаагаар 27.8 сая тонн уул уурхайн бүтээгдэхүүнийг 7.4 их наяд төгрөгөөр арилжаалж өмнөх оны мөн үеэс 17.4 хувиар өссөн бөгөөд үүнээс 21.9 сая тонн цүүрсийг 5.6 их наяд төгрөгөөр арилжаалсан нь нийт арилжааны 76 хувийг эзэлж байна.

График 2. Хөрөнгийн зах зээл






ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ:

- Даатгалын зах зээлд 2025 онд 18 ердийн даатгалын компани, 3 урт хугацааны даатгалын компани, 1 давхар даатгалын компани, 63 даатгалын зуучлагч, 29 хохирол үнэлэгч, 47 аудитын компани, 40 актуарч, 153 аудитор, нийт 354 даатгалын компани, 1,143 даатгалын төлөөлөгч үйл ажиллагаа эрхэлж байна.
- Ердийн^{87.9%}, урт хугацааны^{3.8%}, давхар^{8.8%} даатгалын компаниудын нийт хөрөнгө 771.3 тэрбум тогрогт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 108.5 тэрбум тогрогоор буюу 16.4 хувиар өссөн;
- Даатгалын гэрээг 1,477,077 буюу 81.3 хувийг иргэн, 338,637 буюу 18.6 хувийг хуулийн этгээдтэй байгуулсан бөгөөд нийт 1,815,714 даатгалын гэрээний 51 хувийг жолоочийн хариуцлагын даатгал эзэлжээ;
- Тайлант хугацаанд 584.6 тэрбум төгрөгийн ердийн болон уртын даатгалын болон 195.5 тэрбум төгрөгийн давхар даатгалын хураамжийг төвлөрүүлсэн бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт дүнгээр 81.9 тэрбум тогрогоор буюу 16.2 хувиар өссөн;
- Даатгалын тохиолдлын улмаас 2025 онд нийт 193.7 тэрбум төгрөгийн даатгалын нөхөн төлбөр олгосон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 33.3 тэр бум төгрөгөөр буюу 20.8 хувиар өссөн;
- Даатгалын зуучлалын шимтгэлийн орлого өмнөх оноос 27.4 хувиар өсөж 34.6 тэрбум төгрөг, даатгалын хохирол үнэлэгч компани 6.1 тэрбум төгрөгийн даатгалын хохирол үнэлгээний орлоготой ажилласан нь 1.0 тэрбум төгрөг буюу 19.6 хувийн өсөлттэй;
- Ашигт ажиллагаа 56.0 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 30.5 тэрбум төгрөгөөр буюу 2.2 дахин өссөн;
- Нийт нөөцийн сангийн хэмжээ 352.1 тэрбум төгрөгт хүрсэн нь 22.4 тэрбум төгрөг буюу 22.6 хувиар өссөн;

График 3. Даатгалын зах зээл



БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН САЛБАР:


■ Санхүүгийн зах зээлд 2025 оны жилийн эцсийн байдлаар 575 /Гадаадын хөрөнгө оруулалтаар 26 буюу 4.5 хувь, үндэсний хөрөнгө оруулалтаар 549 буюу 95.5 хувь/ банк бус санхүүгийн байгууллага /Улаанбаатар хотод 477 буюу 83.0 хувь нь байршдаг/ үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд ББСБ-ын тоо өмнөх оны мөн үеэс 0.3 хувиар өссөн;


■ Банк бус санхүүгийн байгууллагуудын эрхэлж буй үйл ажиллагааны төрлүүдийг нийт ББСБ-д эзлэх хэмжээ давхардсан тоогоор Зээлийн үйл ажиллагаа 52.5 хувь, Гадаад валютын арилжаа 16.9 хувь, Итгэлцлийн үйлчилгээ 9.3 хувь, Факторингийн үйлчилгээ 6.1 хувь, Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ 5.6 хувь, Төлбөрийн баталгаа гаргах 3.0 хувь, Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх 5.7 хувь, Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах 0.7 хувь, ҮХЭХБХСЗ 0.1 хувийн тус тус үйлчилгээг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхэлдэг;

- Харилцагчид 4.1 /89.8 хувь нь финтекийн харилцагчид/ сая болж 31.7 хувиар буурсан,
- Нийт зээлдэгчдийн тоо 3.2 /90.1 хувь нь финтекийн зээлдэгчид/ сая болж 39.1 хувиар өссөн;
- ББСБ-уудын нийт хөрөнгийн хэмжээ 2025 оны жилийн эцсийн байдлаар 9.1 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 1.9 их наяд төгрөгөөр буюу 27.4 хувиар өссөн;

- Активын бүтцийн 78.1 хувь буюу 7.1^{/иргэдийн зээл-88.5%, хуулийн этгээдийн зээл-11.5%/} их наяд тогрогийг эргэлтийн хоронго болох зээлийн орийн үлдэгдэл эзэлж байгаа бол пассивын бүтцэд 54.5 хувийг өөрийн хөрөнгө, 45.4 хувийг өр төлбөр тус тус эзэлжээ;
- Хувь нийлүүлсэн хөрөнгө өмнөх оны мөн үеэс 442.9 тэрбум төгрөгөөр буюу 24.7 хувиар өсч 2,233.3 тэрбум төгрөгт хүрсэн;
- Хуримтлагдсан ашиг 746.4 тэрбум төгрөгөөр буюу 43.7 хувиар тус тус өссөн;
- Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт орлогын хэмжээ 48.7 хувиар буюу 889.8 тэрбум төгрөгөөр, нийт зардлын хэмжээ 56.8 хувиар буюу 640.7 тэрбум төгрөгөөр, Цэвэр ашгийн хэмжээ 35.6 хувиар буюу 248.2 тэрбум төгрөгөөр тус тус өссөн;
- Нийт орлогод хүүгийн орлого 88 хувийг эзэлсэн бөгөөд 2025 онд өмнөх оноос 746.5 тэрбум буюу 45.4 хувиар өссөн;
- Нийт зээл 7.2 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 1.4 их наяд буюу 24.1 хувиар өссөн, ЗЖДХ 3.7 хувьд хүрч 0.2 функтээр өссөн;
- Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн эзлэх хувь 8.4 хувьд хүрч 2.3 функтээр өссөн өөрчлөлтүүд гарсан байна.

График 4. Банк бус санхүүгийн байгууллага





ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ САЛБАР:

■ Хадгаламж, зээлийн хоршоодын тоо 2025 оны жилийн эцсийн байдлаар 176^{Улаанбаатар хотод 82 буюу 46.6 хувь, орон нутагт 94 буюу 53.1 хувь/} болсон нь өмнөх оны мөн үеэс 1.1 хувиар буурсан;

■ ХЗХ-дын нийт гишүүдийн тоо 77,155 хүрч 2.5 хувиар өссөн;

■ Активын бүтцийн 78.5 хувь буюу 297.4 тэрбум төгрөгийг эргэлтийн хөрөнгө болох зээлийн өрийн үлдэгдэл эзэлж байгаа бол пассивын бүтэцэд 24.3 хувийг өөрийн хөрөнгө, 74.3 хувийг өр төлбөр ^{/Хадгаламж 73.7%/} тус тус эзэлжээ;

■ Нийт хоронгийн хэмжээ 379.0 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 22.2 тэрбум буюу 6.2 хувиар өссөн;

■ Нийт зээл 290.9 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 32.2 тэрбум төгрөгөөр буюу 12.4 хувиар өссөн;

■ Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн эзлэх хувь 3 хувьд хүрч 0.7 функтээр өссөн;

■ Нийт хадгаламж 261.2 тэрбум төгрөг болж 12.6 тэрбум төгрөгөөр буюу 5.3 хувиар өссөн;

■ Нийт зээлдэгчдийн тоо 591 буюу 2 хувиар буурсан, нийт хадгаламж эзэмшигчдийн тоо 3,678 буюу 8.2 хувиар өссөн;


■ ХЗХ-дын гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн дүн 30.3 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 1.4 хувиар өссөн;

■ ХЗХ-дын хүүгийн орлого 86.7 тэрбум төгрөгт хүрч 17.0 хувь, хүүгийн зардал 44.3 тэрбум төгрөгт хүрч 8.6 хувиар тус тус өссөн;


■ Цэвэр ашиг 2025 онд 17.5 тэрбум төгрөгт хүрч 2.2 тэрбум төгрөг буюу 14.4 хувиар өссөн;

■ Хугацаатай хадгаламжийн жигнэсэн дундаж хүү 1.4 хувь, ЗЖДХ 2.4 хувьтай байна.


График 5. Хадгаламж, зээлийн хориоо



САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ /ТЭРБУМ ТӨГ/




САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ



МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧ:

- Санхүүгийн зах зээл дээр мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч 592 /хуулийн этгээд-382, иргэн-210/ этгээд байгаагаас СЗХ-нд бүртгэлтэй 74 хуулийн этгээд байна.
- Нийт хөрөнгийн хэмжээ 1,421.1 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 461.9 тэрбум төгрөгөөр буюу 48.2 хувиар, нийт зээлийн хэмжээ 840.6 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 30.7 хувиар өссөн;
- Нийт зээлийн өрийн үлдэгдлийн 87.8 хувь нь Улаанбаатар хотод, 12.2 хувь Орон нутагт, байгаа бөгөөд 87.1 хувь нь хэвийн, 12.9 хувь нь хугацаа хэтэрсэн зээл байна.
- Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт орлогын хэмжээ 25.3 хувиар буюу 75.5 тэрбум төгрөгөөр, нийт зардлын хэмжээ 78.9 хувиар буюу 107.1 тэрбум төгрөгөөр өсч, цэвэр ашиг 19.4 хувиар буюу 31.6 тэрбум төгрөгөөр буурч 131.2 тэрбум төгрөг байна.


График 6. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа



ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН САЛБАР

- Санхүүгийн зохицуулах хорооноос 2025 оны жилийн эцсийн байдлаар үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын 289 байгууллага тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхлэж байна. Эдгээр үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагуудын 12 нь хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлж нийт 303 брокер, 1,192 агент ажиллаж байна;
- ҮХЭХЗ-ын байгууллагуудын нийт хөрөнгө 221.2 тэрбум төгрөг бөгөөд өмнөх оны мөн үеэс 3.4 тэрбум төгрөгөөр буюу 1.4 хувиар буурсан;
- Нийт үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагуудын 425 хувьцаа эзэмшигчдийн 5.8 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хороонготэйгоор үйл ажиллагаа эрхэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 20.5 хувиар буурсан;
- Нийт орлого 188.8 тэрбум төгрөгт хүрч 2.3 хувиар, нийт зарлага 183.0 тэрбум төгрөгт болж 0.3 хувиар, цэвэр ашиг 5.8 тэрбум төгрөг буюу 39.6 хувиар буурсан;
- Тайлант онд 4,022.1 мянган м.кв талбай бүхий 3,325.4 тэрбум төгрөгийн үл хөдлөх хөрөнгийг зуучлан худалдсан нь өмнөх оноос 16.7 хувиар, 794.1 мянган м.кв талбай, 301.3 тэрбум төгрөгийн үнэ бүхий үл хөдлөх хөрөнгийг зуучлан түрээслүүлсэн нь өмнөх оноос 20.5 хувиар тус тус оссон байна.

График 7. Үл хөдлөх хөрөнгө зуучлал








ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭГЧДИЙН САЛБАР:

- Тайлант 2025 оны жилийн эцсийн байдлаар 52 хуулийн этгээд, 504 иргэн үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжааг эрхэлж байна;
- Тус салбарт үйл ажиллагаа эрхэлж буй тусгай зөвшөөрөлтэй арилжаа эрхлэгчдийн 72.6 хувь нь Улаанбаатар хотод, үлдсэн 27.4 хувь нь ходоо, орон нутагт үйл ажиллагаа эрхэлдэг;
- Тайлант хугацаанд тусгай зөвшөөрөлтэй 52 хуулийн этгээдийн 82 хувьцаа эзэмшигчдийн 6.3 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа явуулж байгаа нь өмнөх оны мөн үеэс 3.9 тэрбум төгрөгөөр буюу 38.2 хувиар буурсан;
- 2025 оны жилийн эцсийн байдлаар 2.1 тонн үнэт металлыг 615.2 тэрбум төгрөгөөр худалдан авсан нь өмнөх оны мөн үеэс 291.9 тэрбум буюу 90.3 хувиар, 1.7 тонн үнэт металлыг 636.6 тэрбум төгрөгөөр борлуулсан нь өмнөх оны мөн үеэс 311.9 тэрбум буюу 96.1 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.
- Мөн 57.9 тэрбум төгрөгийн үнэт эдлэл худалдан авч, 80.1 тэрбум төгрөгийн үнэт эдлэлийг борлуулсан;
- Нийт орлого 90.4 тэрбум төгрөг, нийт зарлага 76.2 тэрбум төгрөгт хүрч, цэвэр ашиг 14.3 тэрбум төгрөг буюу 14.4 хувиар өссөн байна.

График 8. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч

ЗОХИЦУУЛАЛТТАЙ ЭТГЭЭДИЙН ТОО





ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САН


■ Тайлант онд 79.0 тэрбум төгрөгийн 2,491 батлан даалтыг гаргасан нь өмнөх онтой харьцуулахад батлан даалтын тоо 5.3 дахин, үнийн дүнгээр 4.7 дахин буурсан үзүүлэлттэй;



■ Нийт хөрөнгийн хэмжээ 310.8 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 5.6 тэрбум буюу 1.8 хувиар өссөн;

■ Нийт орлого 23.5 тэрбум төгрөг болж 12 хувиар, нийт зарлага 24.9 тэрбум төгрөгт болж 2 дахин, цэвэр ашиг (1.3) тэрбум 10.9 дахин буурсан;

■ Сангийн батлан даалтын үлдэгдэл 2025 онд 442.0 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 0.4 хувиар өссөн, Батлан даалт гаргасан зээлийн өрийн үлдэгдэл 49.9 тэрбум төгрөгөөр буюу 6.5 дахин өссөн үзүүлэлттэй байна.

График 9. Зээлийн батлан даалтын сан







СЭНДБОКС ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН

- Тайлант хугацаанд Сэндбоксын орчинд 25 хүсэлтийг ирүүлсэн;
- Репо арилжаа хийгдэж 2,361 удаагийн хэлцлээр 508.2 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн нь өмнөх оны мөн үеэс 209.1 тэрбум төгрөгөөр буюу 2.3 дахин өссөн;
- 2025 онд 4 компанийн 6 бүтээгдэхүүн, үйлчилгээ сэндбокс зохицуулалтын орчинд туршигдаж байна.
- B2B зээлийн үйлчилгээний 319 харилцагчийн 157.0 тэрбум төгрөгийн зээл тус платформоор зуучлагдсан нь өмнөх оны мөн үеэс 3.1 дахин өссөн;
- P2P зээлийн үйлчилгээний платформоор 4.1 тэрбум төгрөгийн зээл олгогдсон бөгөөд энэ нь өмнөх оноос 20.6 хувиар өссөн;
- Блокчэйн арилжааны систем дээр нийт 261,540 ширхэг үнэт цаас 28.3 тэрбум төгрөгөөр арилжаалагдсан нь өмнөх оноос 3 дахин өссөн байна. Мөн бондын жигнэсэн дундаж хүү 21.7 хувьтай байна.

График 10. Сэндбокс зохицуулалтын орчин







ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ЗАХ ЗЭЭЛ

- Тайлант 2025 онд нийт 12 компани виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч үйл ажиллагаа эрхлэхээр бүртгүүлсэн;
- Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн харилцагчдын тоо давхардсан тоогоор 709,567 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 23.9 хувиар буурсан бөгөөд эдгээрээс арилжаанд идэвхитэй оролцогчид 2.6 хувь;
- Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн салбарын нийт хөрөнгө 2025 онд 53.9 тэрбум төгрөг бөгөөд өмнөх оноос 24.0 тэрбумаар буюу 30.9 хувиар буурсан;
- Тайлант хугацаанд виртуал хөрөнгийн зээлийн үнэлгээ 250.1 тэрбум төгрөг, зах өдрийн дундаж арилжаа 221.4 сая төгрөг, арилжааны дүн өссөн дүнгээр 80.8 тэрбум төгрөг бөгөөд өмнөх жилээс 19.2 тэрбум төгрөгөөр буюу 31.2 хувиар өссөн;
- Нийт орлого 6.4 тэрбум төгрөг зардал 15.5 тэрбум төгрөгт хүрч 9.1 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу өмнөх оноос 10.3 тэрбум төгрөгөөр алдагдалтай ажилласан.
- Нийт хөрөнгө 53.9 тэрбум төгрөг.

График 11. Виртуал хөрөнгийн Үйлчилгээ үзүүлэгчийн зах зээл





Өнөөгийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ ба харьцуулалтаас харахад санхүүгийн зах зээлийн тоон үзүүлэлтүүдийн дийлэнх нь өссөн үзүүлэлттэй байна.

ГУРАВ. ДҮГНЭЛТ

Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагааны системчилсэн үнэлгээг Байгууллагын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, 2025 оны гүйцэтгэлийн болон үйл ажиллагааны жилийн тайлан, санхүүгийн салбарын тойм, төсвийн гүйцэтгэлийн тайлан, бусад холбогдох баримт материалыг ашиглан, үнэлгээ хийх арга зүйн дагуу үнэлсэн болно.

Үнэлгээний явцад цуглуулсан нотлох баримт, үнэлгээний дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Санхүүгийн зохицуулах хороо нь “Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт”, “Стратеги төлөвлөгөө 2022-2025”, “Хууль тогтоомжид заасан бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилт”, “Хуулиар нийтлэг олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт”, “Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт”, “Хууль тогтоомжид заасан бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилт” бүхий 5 зорилт, 14 дэд зорилт, 160 арга хэмжээг 2025 онд хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан, биелэлтийг хангаж ажилласан байна.


Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу хянах, төлөвлөсөн түвшинд хүрсэн эсэхэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд нэгдсэн дүнгээр 95.0 хувь буюу “Бүрэн хангалттай” үнэлгээний ангилалд хамаарсан үнэлэгдсэн. Хэрэгжүүлсэн нийт арга хэмжээний 92.5 хувь буюу 148 нь “Бүрэн хангалттай”, 6.8 хувь буюу 11 нь “Хангалттай”, 1 хувь буюу 1 нь “Хангалтгүй” ангилалд хамаарч, 5 зорилт тус бүрийн дундаж 91.7-97.8 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд зарим шалгуур үзүүлэлтийг тоон болон чанарын үзүүлэлтээр тодорхойлсон ч хүрсэн түвшинг тодорхойлох боломжгүй тайлагнасан байна. Иймд үр дүнг тайлагнахдаа үйл ажиллагаа буюу процесс тоочих бус гүйцэтгэлийн үр дүн, үр нөлөөг тайлагнахад анхаарах шаардлагатай гэсэн зөвлөмжийг өгсөн.

2. Санхүүгийн зохицуулах хороо нь байгууллагын стратеги төлөвлөгөөний зорилтыг хангасан, зохицуулагч байгууллагууд, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн өмнө тулгамдсан асуудлыг шийдвэрлэсэн, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлж, зохицуулалтын байгууллагуудын чадавхи, үйл ажиллагаанд таатай нөхцөл эрх зүйн орчинг бий болгож, үйл ажиллагааны цахим систем, технологийн орчинг сайжруулан ажилласан.

3. СЗХ-ны зохицуулалтын хүрээ нэмэгдсэнээр 2025 онд нийт 5,930 зохицуулалттай этгээд, 1,143 даатгалын төлөөлөгч бүхий санхүүгийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, иргэний үйл ажиллагааг зохицуулан, хяналт тавьж ажилласан бөгөөд зохицуулалттай этгээдийн тоо сүүлийн 5 жилийн байдлаар тогтмол өсч, 2020 онтой харьцуулахад 45 хувиар нэмэгдсэн байна.

График 12. Зохицуулалттай этгээдийн тоо



4. Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтад хамаарах салбаруудын зах зээлийн үнэлгээ болон нийт хөрөнгө өсөн нэмэгдэж, 2025 оны жилийн эцсийн үйлдвэрлэлийн аргаар тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний (ДНБ) 26.8 хувийг эзэлж байна.

График 13. Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь



5. Тайлант онд дотоодын аж ахуйн нэгжүүд хөрөнгийн зах зээлээс санхүүжилт татах таатай орчныг бүрдүүлэх, үнэт цаасны арилжааны хэмжээг өсгөх болон гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын зах зээлд итгэх итгэлийг нэмэгдүүлэх бодлого, зохицуулалтын цогц арга хэмжээг хэрэгжүүлснээр Монгол Улсын хөрөнгийн зах зээл дэх зохицуулалтын орчинг “Үнэт цаас зээлдүүлэх үйл ажиллагаа” шинэ бүтээгдэхүүн үйлчилгээгээр нэмэгдүүлж хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дараагийн шат руу ахиулах боломжийг бүрдүүлж ажилласан.

Эдгээр бодлого, арга хэмжээний үр дүнд 2025 оны жилийн эцсийн байдлаар Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 13.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 6.6 хувиар буюу 2020 онтой харьцуулахад 4.5 дахин өсчээ. Энэ нь ДНБ-ний 15.6 хувийг эзэлж, хөрөнгийн зах зээлийн хөгжлийн түүхэн дээд өсөлтийг үзүүлсэн байна.

Хөрөнгийн зах зээлд оролцогчдын оролцоог нэмэгдүүлэх, санхүүгийн эх үүсвэр татах үйл ажиллагааг хөнгөвчлөх, мөн бонд гаргахад тавигдах нөхцөл, шаардлагыг хялбаршуулснаар биржийн бус зах зээлийн нийт арилжааны дүн 3.3 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15.7 хувиар өссөн байна.

6. Даатгалын зах зээлийн тогтвортой байдлыг хангах, даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах, даатгалын төлөөлөгч нар мэргэшиж, төрөлжих, даатгуулагч даатгалын талаарх мэдээлэл, үйлчилгээг хүртээмжтэй авах зохицуулалтын орчныг бий болгож, дотоодын даатгалын компаниудын гаргах баталгааны дээд хэмжээ 4 дахин нэмэгдэх, давхар даатгалын оролцоотойгоор бүх төрлийн баталгаа гаргах боломжийг бүрдүүлж баталгааны зохицуулалтыг сайжруулснаар тайлант онд нийт 611.8 тэрбум төгрөгийн 1,299 баталгаа гаргасан байна.

Банк бус санхүүгийн байгууллагуудаас олгож буй хэрэглээний зээлийн хэт өсөлтийг хязгаарлах, иргэд олон нийтийг өрийн дарамтад орохоос сэргийлэх зорилгоор үе шаттайгаар хэрэгжүүлсэн бодлого зохицуулалтын шийдвэрүүд нь иргэдийн өрийн дарамтыг бууруулах, хариуцлагатай зээл олголтыг төлөвшүүлэх, бизнесийн санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд чиглэсэн.

4. Тайлант хугацаанд хуулийн этгээд, иргэд болон зохицуулалттай байгууллагуудаас СЗХ-нд ирүүлсэн бүртгэл, зөвшөөрлийн баримт бичгийн бүрдлийг хянаж, давхардсан тоогоор нийт 2,628 хуулийн этгээдийн тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн хүсэлт болон холбогдох баримт бичгийг хянаж шийдвэрлэсэн байна.

5. Хяналт шалгалтыг зайны хяналт, газар дээрх үзлэг, төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хэлбэрээр хэрэгжүүлж, хяналт тавих чиг үүргийн хүрээнд 659 удаагийн газар дээрх шалгалтыг зохион байгуулж, мөн давхардсан тоогоор сар, улирлын 8,539 санхүүгийн болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайлан, мэдээнд зайны хяналт хийсэн байна.

6. Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгч, иргэн, хуулийн этгээдээс нийт 976 өргөдөл, гомдол ирүүлснийг холбогдох хууль тогтоомжид нь нийцүүлэн шийдвэрлэсэн байна.

7. Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтын салбаруудын зах зээлийн болон эрх зүйн орчны өөрчлөлттэй уялдуулан хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүргийн хүрээнд Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан. Санхүүгийн хоршооны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөлд хадгаламж, зээлийн хоршооны салбарын эрх зүйн орчныг шинэчлэлийг тусгаж олон нийтээс санал авах хэлэлцүүлгийг зохион байгуулан, тус хуулийн төслийг 2025 оны 12 сард УИХ-д өргөн мэдүүлсэн, Даатгалын салбарын эрх зүйн орчныг олон улсын жишигт нийцүүлэн сайжруулах, салбарын хөгжлийг дэмжин “Даатгалын салбарын багц хууль”, “Даатгалын зуучлалын тухай хууль”, “Жолоочийн даатгалын тухай хууль”-иудын шинэчилсэн найруулгын төслийг эцэслэн боловсруулж УИХ-д өргөн барихаар холбогдох арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан байна.

Мөн санхүүгийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ, үнэт цаасны арилжаа, төлбөр тооцооны системийг олон улсын жишигт нийцүүлэх, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын зах зээлд итгэх итгэлийг нэмэгдүүлэх, бүртгэл, мэдээллийн системийг хөгжүүлсэн, зохицуулалтын байгууллагуудын чадавх, үйл ажиллагаанд таатай нөлөөлөх хууль, эрх зүйн орчин бий болсон зэрэг эерэг үр дүнгүүд гарсан байна.

СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭ ХЯНАСАН:

ДОТООД АУДИТЫН ХЭЛТСИЙН ДАРГА



/Т.ГОЦБАЯР/

СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

РЕФЕРЕНТ



/Г.БҮРЭНЖАРГАЛ/